

APU COMPANY

Төгс. Төгөлдөр, Тунгалаг.



ЖИЛИЙН ТАЙЛАН 2023



ҮРГЭЛЖ ӨӨДӨӨ

ЗУУН ЗУУНЫ ТУРШ БИД НҮҮЖ АМЬДАРЧЭЭ.

Нүүдэл бидний харааг тэлж, амьдралыг шинэ өнгө, шинэ агуулгаар баяжуулдаг байв. Гэвч өнөө цагийн амьдралын хэв маяг биднийг хазаарлаж, хараа, бодлыг хаших болов.

Монголчууд бид шинэ газар орон, шинэ талбар, шинэ боломжуудыг нүүдлээрээ нээдэг байлаа.

Эрэл хайгуул, ололт амжилтын төлөө хөдөлгөөн бүр амьдралыг улам баялаг болгоно.

Таних эрмэлзэл дүүрэн, эрэлч, бүтээлч сэтгэлгээ бидний дараагийн том зорилгыг бүтээнэ.

Энэ тэмүүллийн жолоог АПУ-чууд бид атгалцаж,

Эрчлэн сэрээж, илүү утга учиртай, тэгш дүүрэн ирээдүйд хөтөлнө.

Эх дэлхийдээ ээлтэй, эрүүл жаргалтай, баялаг амьдралыг эрэлхийлнэ.

Нүүдэлчдийн цог, хийморийг асааж
ҮРГЭЛЖ ӨӨДӨӨ

For centuries, we've been on the move. Always pushed further and looked for what's beyond. It enriched our lives in many ways. Yet, somehow modern life has settled the world. It stopped us from seeing beyond the horizon.

In Mongolia, we believe the nomadic spirit is the remedy. The life is richer when in motion. When you stay curious, adventurous, and dare to see what's next.

At APU, we are committed to perdure that spirit, in every life we touch.

To lift it up, and fuel it with joy and excitement.

To create more meaningful connections, to stay healthy and in harmony, with each other and nature.

We keep the nomadic spirit alive. So you can keep moving forward.

APU Company, ALWAYS FORWARD

БИДНИЙ ТУХАЙ

Товч түүх	6
Уриа үг	8
Эрхэм зорилго	8
Алсын хараа	9
Үнэт зүйлс	9
Дадал хэвшил	9

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТУЗ-ийн даргын захидал	11
Гүйцэтгэх захирлын захидал	13
Онцлох төсөл, шинэ бүтээн байгуулалт	14
Онцлох үйл явдал	22
Экспортын онцлох үйл явдал	30
Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	32
Хүн төвтэй засаглалын бодлого	34
2023 оны үйл ажиллагааны хураангуй	38
2023 оны санхүүгийн үйл ажиллагааны ерөнхий тойм	39
2023 оны зах зээлийн нөхцөл байдал	40
Гүйцэтгэх удирдлагын дэд баг	42
АПУ Групп компанийн бүтэц	43
Үйлдвэрлэл, үйл ажиллагааны ололт амжилтууд	44
Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлт	47
Дижитал шилжилт ба технологи	48

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн ерөнхий мэдээлэл	51
Хувьцаа эзэмшигчид	51
Төлөөлөн удирдах зөвлөл	53
Хувьцааны мэдээлэл	60
Ногдол ашгийн мэдээлэл	61
Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт	62

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Хамтран бүтээх тогтвортой ирээдүй	65
Тогтвортой түнш	66
Ямагт орших өв соёл	68
Ногоон ба цэвэр тунгалаг	70
Хүчирхэгжсэн хамт олон	74
Баялаг, Хариуцлагатай	76

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

Дэлгэрэнгүй орлогын тайлан	80
Санхүү байдлын тайлан	81
Мөнгөн гүйлгээний тайлан	82
Өмчийн өөрчлөлтийн тайлан	84
Тайлагналын зарчим	85
Тайлбар толь	89

БИДНИЙ ТУХАЙ

- Товч түүх
- Уриа үг
- Эрхэм зорилго
- Алсын хараа
- Үнэт зүйлс
- Дадал хэвшил





1924

Зүүн сэлбийн баруун хөвөөнд таван Монгол, есөн Орос ажилтантай, архи найруулах, савлах гар ажиллагаатай үйлдвэрийг ашиглалтад оруулав.

1961

Ундаа хийжүүлэх, ханд бэлтгэх Болгар улсын тоног төхөөрөмжтэй Ундааны цех байгуулав.



1988

“Оргилуун” брэнд шинээр мэндлэв. Ундааг 0.33 литрийн шилэн саванд савлах 12 мянган лонх/цагийн хүчин чадалтай урсгал шугам бүхий ундааны 2-р үйлдвэрийг шинээр байгуулав.



2001

“АПУ ХК”-ийн нийт хувьцааны төрийн мэдэлд байсан 51 хувийн хувьцааг нийтийн дуудлага худалдаагаар арилжсанаар “АПУ ХК” хувийн өмчид бүрэн шилжив.

2014

Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч Германы GEA компанитай хамтран шинэ сүүний үйлдвэрийг ашиглалтад оруулав.



2021

АПУ компани Монголын анхны нэг их наяд төгрөгийн үнэлгээтэй олон нийтийн компани болж, хүн төвтэй засаглалын бодлогыг шат дараатай амжилттай хэрэгжүүлж “Ажиллахад таатай газар” олон улсын сертификатыг Монгол улсдаа анх удаа гардан авав.



100 ЖИЛИЙН ТОВЧ ТҮҮХ (1924–2024)



1927

Шар айргийг Чех улсын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар Монголчууд анх удаа дотооддоо үйлдвэрлэж эхлэв.



1974

Монголд үйлдвэрлэсэн шар айргаа гадаадад экспортлож эхлэв.

1992

Архи Пивоны комбинатыг АПУ хувьцаат компани болгон зохион байгуулж, нийт хувьцааны 51 хувь төрийн мэдэлд, 49 хувь нь Монголын хөрөнгийн биржээр арилжаалагджээ.



2009

ХБНГУ-ын “Шмитт” компанийн орчин үеийн дэвшилтэт технологиор бүрэн тоноглогдсон “Альфа” буюу тансаг зэрэглэлийн спирт үйлдвэрлэх “Натур Агро” үйлдвэрийг ашиглалтад орууллаа.



2017

Нидерландын HEINEKEN компанийн Монгол дахь эзэмшлийн компаниудыг (М-БИ-СИ Азия Пасифик ХХК, Спирт Бал Бурам ХХК, СББ Трейд ХХК) өөртөө нэгтгэн хүчирхэг нэгдлийг бий болгов.



2023

Уламжлалт технологийг орчин үеийн тоног төхөөрөмжтэй хослуулан бүтээх, “Монгол бяслаг, Шигүдэри” урлах үйлдвэрийг ашиглалтад оруулж, Хонин нуга брэндийг худалдаанд гаргалаа.



УРИА ҮГ / ORGANIZING IDEA

ҮРГЭЛЖ ӨӨДӨӨ
ALWAYS FORWARD



ЭРХЭМ ЗОРИЛГО / MISSION

ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА,
БҮТЭЭХ ТЭМҮҮЛЛЭЭР УРЛАЖ
БУЙ БҮХЭНДЭЭ ҮРГЭЛЖ
СЭТГЭЛЭЭ ШИНГЭЭНЭ.


TO CONTINUOUSLY INNOVATE,
CREATE, AND ENRICH, GUIDED BY
OUR INNER EXPLORING SPIRIT

АЛСЫН ХАРАА / VISION

ДЭЛХИЙД ТАНИГДАХ
ЭРХЭМ МОНГОЛ ХҮМҮҮНИЙ
ОЮУН ЧАДВАР, УР УХААН,
ШИНЭЧЛЭЛ, ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН УНДАРГА БАЙЯ.

TO BE THE PILLAR OF MONGOLIAN
EXCELLENCE IN CRAFTSMANSHIP,
INNOVATION, AND SUSTAINABLE
PRACTICES THAT INSPIRE THE
WORLD

АПУ компани түүхт 100 жилийн ойгоо тохиолдуулан олон улсын Publicis groupe зөвлөх үйлчилгээний агентлагтай хамтран алсын хараа, эрхэм зорилгоо шинэчлэн тодорхойлж, “Үргэлж Өөдөө” уриатайгаар шинэ зуунаа эхлүүлж байна.



ҮНЭТ ЗҮЙЛС / VALUES

CURIOSITY	AUTHENTICITY	CREATIVITY	HUMANENESS
ТАНИХ ЭРМЭЛЗЭЛЧ	ҮНЭН ЧАНАР	БҮТЭЭЛЧ ЧАДВАР	ХҮНДЛЭГ СЭТГЭЛ

ДАДАЛ ХЭВШИЛ / BEHAVIOURS

ЭРЭЛ, ХАЙГУУЛЧ СЭТГЭЭ EXPLORE	ХАМТДАА ЯЛЪЯ WIN	ИННОВАЦИЛАГ АЖИЛЛАЯ INNOVATE	ХҮНДЛЭН ЭРХЭМЛЭЭ CARE
Тасралтгүй шинийг эрэлхийлж, хуваалцаж, суралцаж, туршъя.	Чанарыг эрхэмлэж ялалтын сэтгэлгээгээр урагшилъя.	Уламжлалаа хүндэлж, шинийг бүтээе.	Хүн байхыг чухалчилж, сайн сайхныг түгээе.
Never stop exploring, Learn, share & re-apply	Never compromise on Quality	Embrace innovation & staying true to the roots	Think people first, deliver the goods

02

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТУЗ-ийн даргын захидал
Гүйцэтгэх захирлын захидал
Онцлох төсөл, шинэ бүтээн байгуулалт
Онцлох үйл явдал
Экспортын онцлох үйл явдал
Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
Хүн төвтэй засаглалын бодлого
2023 оны үйл ажиллагааны хураангуй
2023 оны санхүүгийн үйл ажиллагааны ерөнхий тойм
2023 оны зах зээлийн нөхцөл байдал
Гүйцэтгэх удирдлагын дэд баг
АПУ Групп компанийн бүтэц
Үйлдвэрлэл, үйл ажиллагааны ололт амжилтууд
Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлт
Дижитал шилжилт ба технологи



ТУЗ-ИЙН ДАРГЫН ЗАХИДАЛ

ЭРХЭМ ХҮНДЭТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ЭЭ,

Та бүхэндээ АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс 2023 оны санхүү, үйл ажиллагааны үр дүнгээ тайлагнан мэндчилэхэд таатай байна.

Өнгөрсөн онд хууль эрх зүй, макро эдийн засгийн орчинд тодорхой сорилтуудтай

тулгарсан ч чадварлаг хамт олны хүчин чармайлт, өндөр гүйцэтгэлийн үр дүнд санхүүгийн зорилтуудаа биелүүлж, борлуулалтын биет хэмжээ, ашиг орлогоо өсгөн ажиллалаа. АПУ компани хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг дээдлэн, сүүлийн 10 жилийн туршид ногдол ашиг тараалтаар хөрөнгийн зах зээлийг тасралтгүй манлайлсаар ирсэн билээ. Энэхүү уламжлалаа бататган, 2023 оны бүтэн жилийн санхүүгийн үр дүнгээс нэгж хувьцаанд 89 төгрөгийн ногдол ашиг буюу цэвэр ашгийн 80 гаруй хувийг хувьцаа эзэмшигчдэдээ олголоо.

1924 онд Монгол Улсын ууган үйлдвэрийн нэг болж байгуулагдсан АПУ компанийн түүхэн 100 жилийн ойг тохиолдуулан Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн бүх ажилтанд хувьцаа эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн билээ. Ийнхүү, 2024 оны 4-р сарын байдлаар АПУ компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо 29,500 давж, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудаас эхний тавд эрэмбэлэгдлээ.

Зуун жилийг өртөөлөн дараагийн шинэ зуун, хөгжлийн шинэ эрин үеийг угтаж, АПУ компанийн бүхий л бүтээгдэхүүн, үйлдвэрлэл,

үйл ажиллагаанд шинэ санал санаачилгаар үргэлж сэтгэлээ шингээхээ эрхэм зорилго болголоо.

Бид дэлхийд танигдах эрхэм монгол хүмүүний оюун чадвар, ур ухаан, шинийг бүтээх тэмүүллийн ундарга байхыг эрхэмлэн 2024 онд урт хугацааны тогтвортой хөгжлийн зорилгоо тодорхойлж, байнга шинийг эрэлхийлэн, салбарын хөгжлийг түүчээлж, дэлхийн зах зээлд гарах хүчин чармайлтаа эрчимжүүлэн ажиллах болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс АПУ компанийн гүйцэтгэх удирдлагын баг, нийт хамт олондоо нэгэн санаа зорилго доор нэгдэн, санал санаачилга, үр дүн ба гүйцэтгэлээр манлайлан ажиллаж буйд гүн талархал илэрхийлж байна.

Мөн эрхэм хувьцаа эзэмшигчид болон нийт хэрэглэгч та бүхэндээ биднийг үргэлж дэмжин, итгэл хүлээлгэж, үнэнч хэрэглэгч байдагт чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Пүрэвийн Батсайхан

Batsaikhan



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ

Эрхэм хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, хамтран ажилладаг түнш байгууллагууд, хүндэт хэрэглэгч та бүхний амгаланг эрэн мэндчилье.

2023 он бидний хувьд түүхэн зуун жилээ угтсан томоохон бүтээн байгуулалт, соёл, бодлогын шинэчлэлтээр дүүрэн жил байлаа. Ирээдүйн алсын хараагаа тодорхойлж, эрхэм зорилго, үнэт зүйлсээ шинэчлэн, “ҮРГЭЛЖ ӨӨДӨӨ” уриатайгаар 100 жилтэйгээ золгож байна.

Бид олон улсын Publicis groupe зөвлөх үйлчилгээний агентлагтай хамтран ажилласны үр дүнд Монгол өв соёл, нүүдэлчдийн хурд, тэмүүлэл, сэтгэлгээний хурдасгуур бүхэн Монголын онцлог хэмээн бэлгэдэж, Монгол хүний үнэт зүйл, дэлхийд

танигдах цуцашгүй тэмүүлэл, цог хийморийг асааж шинэ уриа, шинэ эрхэм зорилго, шинэ алсын хараагаар шинэ зуунаа эхлүүлээ.

Бидний хувьд 2023 он бүтээн байгуулалтын жил байлаа.

- АПУ ХК сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 26 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж Сэлэнгэ аймгийн Мандал суманд Европын холбооны стандартыг бүрэн хангасан, байгаль орчинд ээлтэй “Монгол бяслаг, Шигүдэри” урлах үйлдвэрийг ашиглалтад орууллаа. Дуураймал бяслагийн импортын хамаарлыг бууруулж, органик бяслагаар дотоодын зах зээлийн 30 хувийг хангахаар зорьж байгаа төдийгүй орон нутагт 30 гаруй шинэ ажлын байр, эдийн засгийн томоохон эргэлт бий болголоо. Үүний зэрэгцээ Монгол үндэстний сүүн шимийн сархад “Шигүдэри” брэндийг үйлдвэрлэн дэлхийн зах зээлд танилцуулж, экспортын бүтээгдэхүүний нэр төрлөө тэлэхээр зорьж байна.

Мөн Архангай аймгийн Чулуут сумын малчидтай 2022 оноос хамтран хэрэгжүүлсэн “Монгол Сарлаг” төслийн үр дүнд анхны малчидтай хамтарсан шилжилтийн үеийн органик хүнсний гэрчилгээтэй сарлагийн сүүн “Mont Yak” брэнд зах зээлд гаргалаа. Энэ төсөл малчдад нэмүү өртөг шингээж түүхий эдээ нийлүүлэх, орон нутагт ажлын байрны үнэ цэнийг өсгөх тогтвортой хөгжлийн зорилтыг хангасан үнэ цэнтэй ажил боллоо.

Үүнээс гадна нийт 50 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар УБ хотын түгжрэлийг бууруулах, баруун бүсийн тээвэрлэлтийн хугацааг 69%, замд өнгөрүүлэх цагийг дунджаар 10 дахин бууруулсан онцгой үр өгөөжийг бий болгосон “Баруун бүсийн агуулах” ашиглалтад орууллаа. Автомат агуулахын систем, цахим удирдлагын систем, санхүү, хүний нөөцийн бүх төрлийн системийн инноваци шингээн 30 гаруй ажлын байр шинээр бий болголоо.

- АПУ ХК олон улсын зах зээлд өргөжин тэлэх ажлаа улам батжуулж өнгөрсөн онтой харьцуулахад нийт экспортын хэмжээ 58%-иар өсөөд

байна. 2023 онд шинээр Казахстан улсын зах зээлд брэнд бүтээгдэхүүнээ нийлүүлж эхэллээ.

- Соёлтой, зөв зохистой хэрэглээ, олон улсын хэрэглээний чиг хандлагыг дагасан шинэлэг соёлыг нэвтрүүлэх бодлогыг онцгойлон чухалчилж хатуулаг багатай, зөөлөн агууламжтай бүтээгдэхүүн, ready to drink буюу коктейль, сахаргүй ундаа, илчлэг багатай зэрэг 90 гаруй нэр төрлүүдийг 2023 онд зах зээлд шинээр нэвтрүүлээд байна.

Түүнчлэн зохистой хэрэглээг сурталчилсан анхны дижитал шошго, хариуцлагатай хэрэглээг уриалсан “Гайхамшигт жолооч – Уусан бол жолоо барьдаггүй” нийгмийн эерэг нөлөөллийн аяныг өрнүүлж 10 мянга гаруй жолооч амлалтаа өгөв. Хэрэглэгч, олон нийтийн соёлтой, хариуцлагатай хэрэглээнд анхаарал тавьж, эергээр нөлөөлөх ажлыг дэмжин ажилласаар байна.

- Монгол улсын төсөвт 437.8 тэрбум төгрөгийн татвар төлсөн нь өмнөх оноос 10% өссөн үзүүлэлт боллоо. Эдийн засгийн өсөлт амаргүй цаг үед бид шинэ бүтээн байгуулалт, шинэ ажлын байр, ажлын байрны шинэчилсэн хангамж, цахим шилжилт, бүтээмжийн бодлого, төлж буй татварын өсөлт, орон нутгийг дэмжих бодлогоор Монгол улсдаа хувь нэмрээ оруулж ажиллахыг зориллоо.

Монгол Улсын хүнсний салбарын 100 жилийн түүхийг бүтээж, хамтын үнэ цэнийг бүтээлцсэн эрхэм хамтрагч, харилцагч, хэрэглэгч, ажиллагсад, хувьцаа эзэмшигч та бүхэндээ талархал дэвшүүлж, дэлхийд өрсөлдөх нэг зорилго дор нэгдэн хамтын ажиллагаагаа улам батжуулна гэдэгт итгэл дүүрэн байна.

Цэвээнжавын ЭРДЭНЭБИЛЭГ

ОНЦЛОХ
ТӨСӨЛ,
ШИНЭ
БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТ

“Монгол бяслаг,
Шигүдэри” урлах
үйлдвэр



“Монгол сарлаг” төслийг
амжилттай хэрэгжүүлж
MONT-YAK брэндийг
шинээр зах зээлд
нэвтрүүлээ



“WEST-HUB”
баруун бүсийн
агуулахыг шинээр
ашиглалтад
орууллаа



“Монгол бяслаг, Шигүдэри” үйлдвэрийг ашиглалтад орууллаа

Монгол Улс жил бүр импортолдог 3000 тонн бяслагийн 10 орчим хувийг эх орондоо үйлдвэрлэх боломж бүрдлээ. Үйлдвэрлэлийн хоёрдогч түүхий эдийг боловсруулан, дээд зэрэглэлийн альбумин уураг, сүүний сархад үйлдвэрлэх төдийгүй сүүний усыг дангаар нь ялган авч үйлдвэрлэлд ашиглах, гадна агаарын хүйтнийг нөөцлөн хөргөлтийн төхөөрөмжийн ачааллыг тэнцвэржүүлж, эрчим хүчний хэрэглээг бууруулах боломжтой, техник, технологийн орчин үеийн шийдэл бүхий цогц үйлдвэр байгууллаа.

Сэлэнгэ аймгийн Мандал сум, Зүүнхараагийн орон нутгийн малчдаас 620 орчим тонн сүү хүлээн авч 62 тонн бяслаг, 11 мянган литр шимийн сархад үйлдвэрлэж байна.

Зах зээлд “Хонин нуга” брэндийн Чеддар, Гоуда, Моццарелла бяслаг, “Шигүдэри” брэндийн 500мл, 750мл-ийн савлагаатай шимийн сархдыг борлуулалтад амжилттай нэвтрүүлэн худалдаалж байна.



2023 онд Хонин нуга, Шигүдэри брэнд нь Стандарт, хэмжил зүйн газраас БАТАЛГААЖСАН тэмдэг, бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээг гардан авав.

Жил бүр болдог Бяслаг урлаачдын фестивалд амжилттай оролцон бяслаг амталгаагаар Япон улсын тэргүүлэгч бяслаг үйлдвэрлэгч Hanabatake Vokujo (Hokkaido)-ийн бяслагийн дараа буюу 2-р байранд шалгарлаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын Шилдэг 35 үйлдвэрлэгчийн нэгээр буюу Орон нутгийн шилдэг үйлдвэрлэгчээр шалгарав.

Bloomberg Awards шалгаруулалтын “Шилдэг бүтээн байгуулалт” номинацийн эзэн боллоо.



“Монгол Сарлаг” төслийг амжилттай хэрэгжүүлж MONT-YAK брэндийг зах зээлд нэвтрүүлээ

Уламжлал, өв соёлоо орчин үеийн дэвшилтэт технологитой хослуулсан бүтээмжид суурилсан хөдөлмөр хөнгөвчлөх технологийг нэвтрүүлэх замаар сүү, сүүн бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх, малчдыг тогтмол орлоготой болгоход хувь нэмрээ оруулах зорилготойгоор “Гэр Үйлдвэрлэл” төслийг 2022 онд санаачлан хэрэгжүүлж эхэлсэн. Улмаар сарлагийн мал аж ахуй эрхлэлт, түүний онцлог шинж чанар, өрхийн үйлдвэрлэлийн боломжийг үнэлэх, саалийн гарц чанарыг нэмэгдүүлэх, малчдын хөдөлмөр хөнгөвчлөх зорилгоор “Сарлагийн саалтуур” төслийн ТЭЗҮ боловсруулж хэрэгжүүлсэн. Архангай аймгийн Чулуут суманд хэрэгжиж буй “Монгол сарлаг” хөтөлбөрийг 30 өрхийг хамруулан “Гэр үйлдвэрлэл”-ийн загвараар, орон нутагт нэмүү өртөг шингээн хэрэгжүүлж байна. Төслийн гол онцлог нь хуванцар савны хэрэглээг 100% халж, чанар стандартын шаардлага хангасан түүхий эдээр бэлтгэн нийлүүлэхэд оршиж байна.



Шилжилтийн үеийн органик хүнс гэрчилгээг хүлээн авч буй

Ийнхүү Mont-Yak брэндийн 9 нэр төрөл бүхий сарлагийн сүүн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн гарт хүргэж эхэллээ. Сүү бэлтгэх анхан шатнаас эцсийн бүтээгдэхүүн хүртэлх бүхий л дамжлагыг стандартжуулж органик хүнсний шаардлагыг ханган хайлмаг болон шар тосон дээр **ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН ОРГАНИК ХҮНС** гэрчилгээг гардан авч тухайн нэр төрөлдөө анх удаагаа малчидтай хамтран органик хүнсний гэрчилгээ хүртсэн үйлдвэрлэл болж байна.



“WEST-HUB” БАРУУН БҮСИЙН АГУУЛАХ

Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, баруун бүсийн тээвэрлэлтийн хугацааг 69%, замд өнгөрүүлэх цагийг дунджаар 10 дахин бууруулах онцгой үр өгөөжийг бий болгосон “Баруун бүсийн агуулах”-ыг бүтээн байгууллаа. Энэ төсөл нь автомат агуулахын систем, цахим удирдлагын систем, санхүү, хүний нөөцийн бүх төрлийн системийн инновац шингээсэн орчин үеийн бүрэн автомат агуулах юм.



“ Монголдоо төдийгүй Азидаа томоохонд тооцогдох бүрэн автомат энэхүү агуулахын төслийн бүтээн байгуулалт гурван жилийн турш өрнөж ийнхүү ашиглалтад орлоо. Сонгинохайрхан дүүрэгт байрлах энэ агуулах нь хүлэмжийн хийг бууруулах, зам тээврийн ачааллыг бууруулах тогтвортой хөгжлийн өндөр ач холбогдолтой төсөл юм.

**АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал
Ц.Эрдэнэбилэг**

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Ажилтан бүр
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ
болов



Хагас зуунаар
баталгаажсан
ХАМТЫН ҮНЭ ЦЭН

/Спирт Бал Бурам ХХК-ийн
50 жилийн ой/



"Монгол бяслаг,
Шигүдэри" урлах
үйлдвэрт Монгол
Улсын Ерөнхийлөгч
Ухнаагийн Хүрэлсүх
зочиллоо






АЖИЛТАН БҮР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ БОЛОВ

Шунхлай групп нийт ажилтандаа АПУ ХК-ийн хувьцаа эзэмших эрхийг олгож, ажилтан бүр эзний ёсоор хандаж хамтын үнэ цэнийг хүртдэг шинэ давалгааг эхлүүллээ.

АПУ ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 12 сарын 05-ны өдрийн тогтоолоор "АПУ ХК-ийн 1,206,810 ширхэг халаасны хувьцааг дахин гаргах замаар, ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр"-ийг баталж, ажилласан жилийг 100 ширхэг хувьцаагаар үржүүлэн хувьцаа эзэмшүүлэхээр шийдвэрлэлээ.



ИРЭЭДҮЙГ БҮТЭЭХ ХҮСЭЛ ТЭМҮҮЛЭЛ



**“Монгол бяслаг,
Шигүдэри” урлах
үйлдвэрт Монгол
Улсын Ерөнхийлөгч
Ухнаагийн Хүрэлсүх
зочиллоо**



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн хүнсний хангамж, аюулгүй байдал, тэр дундаа эрүүл чанартай хүнсийг Монгол хүн бүрд хүргэх зорилгоор хүнсний салбарт ажиллаж буй хувийн хэвшлүүдтэй хамтран ажиллаж буй билээ. Энэхүү хамтын ажиллагааны нэг хэсэг болж АПУ компаниас “Цагаан хувьсгал” санаачилгыг 2023 оны 03 сард дэвшүүлж, 8 зорилтын хүрээнд сүүний салбарт манлайлж ажиллахаа илэрхийлсэн. Үүний хүрээнд “Монгол бяслаг, Шигүдэри” урлах үйлдвэрт зочлон танилцлаа.



“Эх орноо эрүүл хүнсээр хангах, хүнс экспортлогч болох их үйлсэд хүч хөдөлмөр, сэтгэл зүрх, хичээл зүтгэлээ дайчлан ажиллаж байгаа эрхэм хүндэт та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлээд, уламжлалт сүү боловсруулах арга барилыг сүүлийн үеийн техник технологитой хослуулан хөгжүүлж, дэлхийн стандартад нийцсэн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг цаг үе биднээс шаардаж байна.”

Монгол Улсын Ерөнхийлөгч
Ухнаагийн ХҮРЭЛСҮХ



ХАГАС ЗУУНААР БАТАЛГААЖСАН ХАМТЫН ҮНЭ ЦЭН

АПУ ХК-ийн Спирт Бал Бурам ХХК нь 1973 онд үүсгэн байгуулагдсан цагаасаа орон нутгийн хөгжил цэцэглэлт, эдийн засаг, хүн ам, нийгэмдээ өндөр хувь нэмэр оруулж, хамтран ажиллаж буй байгууллага, газар тариалан эрхлэгчидтэйгээ хамт хагас зуун дамжин өвлөгдөх чанар, соёл, хөгжил бүтээх үнэ цэнийг тасралтгүй бүтээж байна.



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн 2023 оны 07-р сарын 07-ны өдрийн 101 дүгээр зарлигаар АПУ ХК-ийн охин компани Спирт Бал Бурам ХХК Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон гардан авлаа.

Өдгөө АПУ компанийн Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Спирт Бал Бурам” компанид нийт 300 гаруй хүн ажиллаж, сүүлийн 5 жилийн хугацаанд 367 тэрбум гаруй төгрөгийн татварыг төлж, сум орон нутгийн нийт 40 гаруй газар тариалан эрхлэгч, 580 гаруй малчид фермерүүдтэй тогтмол хамтран ажиллаж байна.



ХАГАС ЗУУНААР
БАТАЛГААЖСАН
ХАМТЫН
ҮНЭ ЦЭН
СПИРТ БАЛ БУРАМ



2023 ОНЫ ОНЦЛОХ ЭКСПОРТЫН ҮЙЛ ЯВДАЛ

Энэ онд экспортын үйл ажиллагаа хүрээгээ тэлж **Казакстан, Итали, Швейцарь**, болон **Герман** зэрэг улсын зах зээлд амжилттай нэвтэрч эхэллээ. **ОХУ** руу Агар, Алтан говь, Сэнгүр, Боргио болон Тэрэлж, Сэлэнгэ брэнд, **Тайланд** улс руу Эден, Соёмбо брэнд, **БНХАУ**-д Чингис Хаан, Соёмбо, болон Eden, **АНУ**-ын онлайн худалдааны зах зээлд Чингис хаан брэнд, **БНСУ**-д Алтан говь, Eden брэнд зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүнийг экспортолж эхэллээ.

- www.chinggiskhan.com сайтаар дамжуулан брэнд бүтээгдэхүүнээ АНУ-д худалдаалж эхлэв.
- Европын зах зээлийн харилцагч, хэрэглэгчидтэйгээ илүү ойр ажиллах, бүтээгдэхүүнээ аль ч зах зээлээс худалдан авах боломжийг бүрдүүлэх зорилгоор Нидерланд улсын Роттердам хотод Олон улсын агуулах тээвэр түгээлтийн компанитай хамтарч эхлэв.
- Төр, Хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, Монгол улсын соёлыг түгээх үйлсэд манлайлан оролцож Тайланд, АНУ, Канадын элчин сайдын яамдуудтай хамтран ажиллалаа.



АНУ-ын Вашингтон хотод “Chinggis Khan Cup” арга хэмжээтэй хамтран ажиллав.



Robb Report Thailand сэтгүүл, The Spirit Business сэтгүүлд брэнд бүтээгдэхүүнийг онцлов.



БНСУ-ын Сөүл хот дахь Хапжунг гудамжинд байрлах GS25-ын салбарт “Алтан Говь” брэндийн POP-UP дэлгүүр ажиллаж эхлэв. Мөн GS25 Music and Beer фестивалд бүтээгдэхүүнээ танилцуулан оролцов.



ОХУ-ын “Оны шилдэг хүн” шалгаруулах үйл ажиллагаатай хамтран ажиллав.



БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод Олон улсын худалдаа хөрөнгө оруулалтын үзэсгэлэнд оролцов.



Казахстан улсад “Монголын нэг өдөр” танилцуулах арга хэмжээг зохион байгуулж брэнд бүтээгдэхүүнээ худалдаалж эхэллээ.



Tommy bar Eden арга хэмжээг ОХУ-д зохион байгууллаа.



БНХАУ-д Miracles of Eden харилцагчийн арга хэмжээг зохион байгууллаа.

СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Болгар улс бол таргийн соёлоороо дэлхийд алдартай орон бөгөөд Болгарчууд урт наслалтаараа тэргүүлэгч орнуудын нэг юм. Тэдний урт наслалтын нууцыг 1907 онд Нобелийн шагналтан Оросын эрдэмтэн, насжилт, дархлал судлаач Иля Мэчников /Ilya Metchnikoff/ Lactobacillus Bulgaricus бактерийг шинжлэх ухааны түвшинд анх судалсан ба Болгар таргийн хөрөнгөнд байх ашигтай бактери нь хүний дархлааг дэмждэг, эрүүл мэнд, хөгшрөлтийн эсрэг үзүүлэх ач тустай болохыг онцолсон байдаг.



Болгар таргийн хөрөнгийг албан ёсны эрхтэйгээр Монголдоо оруулж ирэх цорын ганц эрхийг APU DAIRY Монгол сүүний үйлдвэр авч, хамтын ажиллагааны гэрээнд үзэглэсэн Азийн 2 дахь орон болов.



ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ЭРҮҮЛ ИННОВАЦ

Ашиглахад хялбар 250 мл савлагаатай сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх шугамыг ашиглалтад оруулж, хүүхдэд зориулсан импортыг орлох жижиг савлагаатай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж эхэллээ.

Мөн эрүүл мэндийг дэмжих Д амин дэмтэй сүү болон малын гаралтай сүүнээс харшилтай хүмүүст зориулсан лактозгүй сүү, байгалийн анагаах хүчтэй цэцгийн зөөлөн тааламжит амтыг монгол үнээний цэвэр сүүтэй хослуулсан сафрон цэцгийн орцтой сүү гэх мэт эрүүл амьдралын хэв маягийг дэмжих бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг үргэлжлүүлсээр байна.



ХҮН ТӨВТЭЙ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

COACHING хөтөлбөр

АПУ компанийн хэмжээнд Coaching соёлыг бий болгох зорилгоор 28 удирдах түвшний ажилтныг COACH-ээр бэлтгэн 56 хүнийг хамруулсан хөтөлбөр хэрэгжүүллээ. Нийт 9 сар үргэлжилсэн энэ хөтөлбөрийн тоон мэдээллээс дурдвал:



Ганцаарчилсан coach уулзалтад зарцуулсан цаг

84+



Ажиглалттай coaching уулзалтад зарцуулсан цаг

112



Сургалт болон холбогдох үйл ажиллагаанд зарцуулсан цаг

30+



Хөтөлбөрийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн цаг

20+

Coach нарын дунд явуулсан судалгаагаар 91% нь өөрийн ур чадварыг маш сайн болон сайн гэж дүгнэсэн байна. Хөтөлбөрийн үр дүнд удирдах ажилтнуудын удирдах ур чадвар, көүч хийх ур чадвар дээшилснээс гадна зөв асуулт асуух, сонсох, асуудлын шийдэл олох ур чадварууд нэмэгдсэн. Ажилтнуудын хувьд өөртөө итгэх итгэл нэмэгдэх, өөрийгөө таньж нээх, зорилгуудаа зөв тодорхойлж түүнийгээ биелүүлэх, боломжуудыг харж чаддаг болсон.

LEADER'S MINDSET ХӨТӨЛБӨР



Leader's mindset хөтөлбөрт чиг үүрэг тус бүрийн дотоод ажилтнуудаас сонгосон ба сургагч багш нарыг бэлтгэхдээ ORP Institute of Korea /Korean and Mongolian Consultants/ институтын Манлайллын сургалтыг дүүргэж, цааш удирдлагуудад заах арга барил эзэмших сургалт болон бэлтгэл ажилд нийт 242 цагийг зарцууллаа.

2023 оны 05-р сараас 09-р сарыг дуустал хугацаанд 8 ангийг 16 удаагийн давтамжтай 128 цагийн сургалтыг 140 удирдлага, менежер, ахлах ажилтнуудыг хамрууллаа.

APU LIFE ХӨТӨЛБӨР

АПУ ХК ажил, амьдралын тэнцвэрийг хадгалах, ажилтан бүрийн бие болон сэтгэл зүйн цогц эрүүл мэндийг дэмжих боломжийг олгох, уян хатан ажлын цаг зэрэг ажилтнууд руугаа чиглэсэн "APU Life" хөтөлбөр, сургалт хөгжлийн "APU Academy", "Менторшип хөтөлбөр", шинэ ажилтан чиглүүлэх "Fast track" хөтөлбөр, "Удирдах ажилтны цогц манлайллын хөтөлбөр", "Coaching" хөтөлбөр гэх мэт зорилтот олон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байна.

GIVING DAY

Ажилтнууд өөр хоорондоо хэрэгцээт зүйлсээ солилцох боломжийг олгох зорилгоор Giving day 2023 хөтөлбөрийг зохион байгуулав. Тус хөтөлбөрөөр цугларсан ажилтнуудын эд зүйлсийг "Цэцээ гүн ротаракт" клубтэй хамтран үер усны гамшигт өртсөн найман дүүргийн 14 хорооны иргэдэд өгөв.



MUSIC THERAPY

Ажилтан бүрийн ажил, амьдралын тэнцвэрийг хадгалахад туслах, бие болон сэтгэл санааны эрүүл мэндэд анхаарах, сайн сайхан байдлын талаар бие биетэйгээ нээлттэйгээр ярилцдаг соёл, дадлыг бий болгох зорилгоор Ажилтнуудын стрессийг бууруулах, өдрийг эрч хүчтэй эхлүүлэх, сэтгэл санааг дэмжиж ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор байршил бүр дээр Aroma therapy болон Music therapy-г хэрэгжүүллээ.



THINK FRIDAY

Ажилтнуудын шинэ санаа, бүтээлч байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Think Friday үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.





BOOSTIBE

Innovative Benefit
ТӨСӨЛ



Ажилтнуудынхаа сурч хөгжих эрмэлзэл, хэрэгцээ шаардлагын ялгаатай байдал, эрүүл амьдралын хэв маягийг бий болгох, гэр бүл, хувийн амьдралдаа анхаарал хандуулах, цаг зарцуулах зэрэг хүсэл хэрэгцээнд тулгуурлан өөрт хэрэгцээт урамшууллыг ажилтан өөрөө сонгох боломжийг олгосон BOOSTIBE хөнгөлөлт, урамшууллын инновацилаг хөтөлбөрийг хэрэгжүүллээ. Ажилтан компанитай урт удаан хугацаанд хамтын аялал хийх тусам хөнгөлөлт, урамшуулал авах үйлчилгээний эрх, үнийн дүн нэмэгддэг систем нэвтрүүлснээр АЖИЛЛАХАД ТААТАЙ АЖЛЫН БАЙР бүрдүүлж байна.



CRAFT YOUR CAREER

Дэлхийд өрсөлдөх үндэсний компани болох АПУ ХК нь олон нийтэд чиглэсэн "CRAFT YOUR CAREER - Карьераа урла" ажлын байрны нээлттэй өдөрлөгийг цуврал байдлаар зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр АПУ ХК-ийн бүтэц, хүн төвтэй засаглал, тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг танилцуулан, автобус үйлчилгээ, урлагийн


тоглолт, АПУ үйлдвэрийн аялал, хөгжөөнт тэмцээн гэх мэт олон үйл ажиллагааг зохион байгуулав. Мөн Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, Гадаад Төгсөгчдийн Холбоо, HR CLUB хамтран зохион байгуулсан CAREER EXPO-2023 залуучуудын хөдөлмөрийн өдөрлөгийг АПУ компани дэмжин ажиллалаа.

Энэхүү үйл ажиллагаа нь эх орондоо болон гадаадад сурч, ажиллаж буй залуучуудын хөгжил, хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн харилцааны хүрэн дэх хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааг сурталчлан таниулах байнгын болон цагийн ажилд зуучлах зорилготой. Уг арга хэмжээнд АПУ ХК-ийн зүгээс нээлттэй сонгон шалгаруулалтын цахим системээ танилцуулж, нээлттэй зарлаж буй ажлын байрандаа хүний нөөцийн бүрдүүлэлт хийсэн юм.



АПУ ХК үйл ажиллагааны цахим шилжилтийн хүрээнд хүний нөөцийн нээлттэй сонгон шалгаруулалтын <https://hello.apu.mn/> сайтыг олон нийтэд танилцууллаа. Уг сайтаар нэвтэрснээр АПУ групп компанид анкет хүлээн авч байгаа нийт нээлттэй зарыг нэг дороос харж, материалаа өгөх боломжтой юм. Ингэснээр нээлттэй сонгон шалгаруулалтыг хүртээмжтэй, түргэн шуурхай, хүссэн газраасаа хандах боломжтой болголоо.

2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ



2023 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТОЙМ

Тоон үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан		Өөрчлөлт %
		2023	2022	
БОРЛУУЛАЛТЫН ТОО ХЭМЖЭЭ				
БОРЛУУЛАЛТЫН ТОО ХЭМЖЭЭ	мян.литр	170,960	158,800	8% ↑
ОРЛОГО ҮР ДҮН				
Цэвэр борлуулалтын орлого	сая.төг	1,105,352	850,240	30% ↑
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	175,345	164,452	7% ↑
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	117,058	125,898	7% ↓
БАЛАНС				
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	448,952	351,152	28% ↑
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	569,529	490,982	16% ↑
Нийт хөрөнгө	сая.төг	1,018,481	842,134	21% ↑
Нийт өр төлбөр	сая.төг	337,906	208,557	62% ↑
Нийт эздийн өмч	сая.төг	680,576	633,577	7% ↑
Нийт эздийн өмч ба өр төлбөр	сая.төг	1,018,481	842,134	21% ↑
МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	184,383	112,646	64% ↑
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(117,469)	(92,777)	27% ↓
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	18,853	(60,639)	131% ↑
Бусад мөнгөн гүйлгээ	сая.төг	(1,980)	1,857	207% ↓
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	83,787	(38,913)	315% ↑
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	сая.төг	38,365	77,278	50% ↓
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	сая.төг	122,152	38,365	218% ↑
ТАТВАР ТӨЛӨЛТ				
Онцгой албан татвар	сая.төг	236,044	196,919	20% ↑
Нэмэгдсэн өртгийн албан татвар	сая.төг	90,049	71,989	25% ↑
Бусад	сая.төг	111,720	128,588	13% ↓
Нийт татвар төлөлт	сая.төг	437,813	397,495	10% ↑
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ				
Нийт хөрөнгө оруулалт	сая.төг	109,486	86,529	27% ↑

2023 ОНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

АРХИН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ

2023 онд Монгол Улсын архин бүтээгдэхүүний зах зээл биет хэмжээгээр 28.3 сая литр хүрсэн байна. АПУ ХК нь 2023 оны байдлаар нийт 19 архины төрлийн брэнд бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлж байна.

ШАР АЙРГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2023 онд Монгол улсын шар айргийн зах зээл биет хэмжээгээр 122 сая литр хүрсэн байна. 2023 оны байдлаар шар айргийн нийт 12 брэндийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлж байна.

УС, УНДАА, ШҮҮСНИЙ ЗАХ ЗЭЭЛ

2023 онд Монгол улсын ус ундааны зах зээл биет хэмжээгээр 440 сая литр хүрсэн байна. 2023 оны байдлаар ус ундааны нийт 5 брэндийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлж байна.

СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ

Монгол улсын сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл биет хэмжээгээр 99.1 сая литр хүрсэн байна. Апу Дэйри ХХК нь 2023 оны байдлаар сүү сүүн бүтээгдэхүүний нийт 8 брэндийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлж байна.

ДАРСНЫ ЗАХ ЗЭЭЛ

2023 онд Монгол улсын дарсны зах зээл биет хэмжээгээр 3.55 сая литр хүрсэн байна. 2023 оны байдлаар дарсны нийт 14 брэндийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлж байна.

ИМПОРТЫН ВИСКИ БОЛОН БУСАД ЗАХ ЗЭЭЛ

2023 онд Монгол Улсын импортоор орж ирж байгаа виски болон бусад бор спиртэн бүтээгдэхүүний нийт зах зээл 1.04 сая литр хүрсэн байна. 2023 оны байдлаар нийт 17 брэндийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд нийлүүлж байна.



Эх сурвалж: /АПУ ХК-ийн дотоод судалгаа/



ГҮЙЦЭТГЭХ ДЭД УДИРДЛАГЫН БАГ



Цэвээнжавын
ЭРДЭНЭБИЛЭГ
Гүйцэтгэх захирал



Дандарова
АРИУНА
Глобал худалдаа
эрхэлсэн захирал



Батсайханы
ЦАЦРАЛ
Борлуулалт, маркетинг
эрхэлсэн захирал



Жаргалсайханы
ИЧИНХОРЛОО
Захиргаа, Хүний нөөц
эрхэлсэн захирал



Добрев
НИКОЛАЙ
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа
эрхэлсэн захирал



Гончигийн
ЭНХБИЛЭГ
Санхүү эрхэлсэн захирал,
Төслийн удирдлагын
захирал



Галсумъяагийн
БАЯРМАГНАЙ
АПУ Дэйри ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



Батсайханы
ГАНТИГ
Стратеги эрхэлсэн захирал

АПУ ГРУПП КОМПАНИЙН БҮТЭЦ

APU COMPANY
Absolute. Pure. Unique.

APU DAIRY
МОНГОЛ СҮҮНИЙ ҮЙЛДВЭР

SBBT

Grand

SBB

**CHINGGIS KHAN
INTERNATIONAL LIMITED**

ГРАНД ИСТ
Absolute. Pure. Unique.

ХАРААТ КОМПАНИ

**DIGITAL
CONCEPT**

APU TRADING
Absolute. Pure. Unique.

MBC ASIA PACIFIC

爱啤酒
Inner Mongolia APU trading company

ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОЛОЛТ АМЖИЛТ

ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АКАДЕМИ



Үйлдвэрлэл, үйл ажиллагааны газрын ажиллагсдыг мэргэжлийн чиглэлд ХАЙНЕКЕН стандартаар олон улсын түвшинд хөгжүүлэх, суралцах боломжоор ханган, ажилтнууддаа нарийн мэргэжлээр мэргэших, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллалаа.

ГҮЙЦЭТГЭЛД

ЧИГЛЭСЭН СУРГАЛТ

Мэргэжлийн комиссоор хянагдсан сургалтууд болон дадлага ажлуудыг 100 хувь төлөвлөгөөний дагуу явуулж, операторуудад зориулсан танхимын сургалтыг бэлтгэн зохион байгуулав. Мөн түүнчлэн бүх сургалтаа АПУ LMS 365 платформ дээр байрлуулсан цахимжуулж үйлдвэрийн эрүүл ахуй, Шар айраг үйлдвэрлэл, Qualass програм, Чанарын удирдлагын тогтолцоо, Инженерингийн 12 тоног төхөөрөмж, Бүтээмжийн удирдлагын систем зэрэг бүхий л сургалтыг байршууллаа.

Үйлдвэрлэл, үйл ажиллагааны академийн 36 мэргэжлийн сургагч багш нар бэлтгэгдэн **27 воркшоп, 69 танхимын сургалтыг амжилттай зохион байгууллаа.**

НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ

Академийн үйл ажиллагааг таниулан сурталчлах OPEN DAY арга хэмжээ 08-р сарын 30-аас 10-р сарын 12-ны өдрүүдэд Төв АПУ, Натур Агро Спиртийн үйлдвэр, М Би Си Шар Айраг үйлдвэр, Спирт Бал Бурам спиртийн үйлдвэрт амжилттай зохион байгуулж NEVER STOP LEARNING уриатайгаар зохион байгуулагдсан тус үйл ажиллагаанд давхардсан тоогоор 400 гаруй ажилчид хамрагдан Supply Chain Академийн үйл ажиллагааны тайлан, цаашдын зорилт хөтөлбөр мөн LMS 365 платформын талаар дэлгэрэнгүй мэдээллийг түгээлээ.



АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА



Дэлхийн ХАБЭА-н өдөр 2023 оны 4-р сарын 28-ныг тохиолдуулан АПУ групп компанийн хэмжээнд нийт 10 үйлдвэр, компанийн дунд “Аюулгүй ажиллагааны манлайлагч” авьяас, мэдлэг сорих уралдаант тэмцээнийг зохион байгуулж шилдэг багуудыг шалгаруулан аюулгүй ажиллагааны мэдлэгийг түгээлээ.

Монгол орон даяар бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэдэг том оврын 110 тээврийн хэрэгслүүдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ шат дараалан авч 2023 онд замын хөдөлгөөний осол, гэмтэл огт бүртгэгдээгүй амжилттай ажиллалаа.

Ур чавдарын уралдаан



Агуулах, тээвэр түгээлтийн үйл ажиллагааг тасралтгүй ханган ажилладаг 50 сэрээт өргөгч машины жолооч нарын дунд “Ур чавдарын уралдаан”-ыг зохион байгуулж аюулгүй ажиллагаа, ур чавдарыг бусдадаа хуваалцан ажиллав.



АМТАЛГААНЫ ЛАБОРАТОРИ

АПУ компанийн үйлдвэрлэж буй брэнд бүтээгдэхүүн бүрийн профайл амтыг гаргаж, тухайн амтыг тогтвортой байлгах зорилготой Амталгааны лабораторийг групп компанийн бүх үйлдвэрт нэвтрүүлээ. Мөн мэргэжлийн амтлагч болон GO-NGO амтлагч нар бэлтгэгдэв.



ДАВТАГДАШГҮЙ СОЁЛ, ҮНЭТ ӨВ



ARU COMPANY
Төгс, Төгөлдөр, Тунгалаг

ҮРГЭЛЖ ӨӨДӨӨ

ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

2023 онд шинэ бүтээгдэхүүний жор орц тогтоох, туршилт судалгааг тасралтгүй хийж, туршилтын үйлдвэрлэл хийх, масс үйлдвэрлэлийн дүгнэлт гаргах, хаяг шошгын мэдээлэл боловсруулах, хянах ажлуудыг тасралтгүй хийж Алтан говь Rose, Оргилуун цагаан гаатай төрлийн

туршилтыг амжилттай хийж худалдаанд гаргалаа. Мөн Sleek Can, PET, Лаазан савлагаатай цоо шинэхэн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэж Ooze, Оргилуун ZERO, Тэрэлж, Сэлэнгэ NFT, Боргио Хурд, Playtime тэргүүтэй 10 гаруй брэндийн савлагааны шинэчлэлийг богино

хугацаанд өндөр хурдтай хийж гүйцэтгэлээ. Multi-rack савлагааны төхөөрөмж шинээр суурилуулснаар 4, 6 ширхгээр савласан бүтээгдэхүүн хэрэглэгчдэд хүрэх боломжийг нээж, илүү бүтээлч, шинэ инновац нэвтрэх суурийг бэхжүүлээ.



ИННОВАЦ - ШИНЭЧЛЭЛ



READY TO DRINK
КОКТЕЙЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ
ШИНЭ СОЁЛ



УЛАМЖЛАЛ - ШИНЭЧЛЭЛ



ХАТУУЛАГ БАГАТАЙ
БҮТЭЭГДЭХҮҮН

ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ БА ТЕХНОЛОГИ

Үйлдвэрлэл, үйл ажиллагааны “Дижитал технологи” стратегийн хүрээнд үндсэн процессыг автоматжуулан, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “Digital TPM”, “Maximo”, “Soptimize” төслүүдийг хэрэгжүүлж ажиллав.

“DIGITAL TPM”:

Бид бүтээмжийн удирдлагын процессыг автоматжуулах “TPM system” төслийг амжилттай хэрэгжүүлж, Үйлдвэр, үйл ажиллагааны бүх алба нэгжүүдэд нэвтрүүллээ. Heineken компанийн өндөр гүйцэтгэлийн соёл, тасралтгүй сайжруулалт бий болгох Бүтээмжийн удирдлагын систем /TPM/ 2009 оноос эхлэн ЭМ БИ СИ Шар айргийн үйлдвэрт нутагшуулж, 2018 оноос Бүтээмжийн удирдлагын системийн дараагийн түвшинд шилжиж TPM next шинэчлэгдэн АПУ төв үйлдвэр, Спиртийн үйлдвэр, Дэйри болон Ложистикийн хэсгүүдийг хамран БУС (Бүтээмжийн Удирдлагын Систем)-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2023 онд “БУС” нь TPM2WIN болж дахин шинэчлэгдлээ.

MAXIMO ТӨСӨЛ:

Тоног төхөөрөмжийн үндсэн бүртгэл, сэлбэгийн бүртгэл, удирдлага, тайлагналын систем, засвар үйлчилгээ, сэлбэгийн худалдан авалт, засварын тайлагнал тэргүүтэй үндсэн 5 чиглэлд бүх процессыг автоматжуулж MAXIMO серверийг Сингапур улсаас нүүлгэн дотоодын Дата центрт байршуулснаар засвар үйлчилгээ, сэлбэгийн оновчтой удирдлага, зардлын хэмнэлт, нэгдсэн датанд суурилсан оновчтой шийдвэр гаргах боломжийг бүрдүүлсэн цогц ажил хэрэгжүүлж ажиллалаа. Ийнхүү инженерингийн үйл ажиллагааны хяналт удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлж групп компанийн 550 машин тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг бүртгэдэг боллоо. Төслийн хүрээнд автоматжуулалтын тусламжтайгаар компанийн ажлын урсгалыг сайжруулах зардал, цаг хугацаа, алдагдлыг бууруулж, бүтээмжийг нэмэгдүүлж үйлдвэрлэлийн үйл явцыг хянах боломжтой болж байна.

SOPtimize төсөл:

Үндсэн үйлдвэрүүд, агуулах, тээвэр түгээлт, савлалт, борлуулалт, экспорт, импортын алба тэргүүтэй 13 алба, нэгжийн 50 гаруй ажиллагсад хамтарсан энэхүү төсөл нь борлуулалтын таамаглал, нийлүүлэлтийн төлөвлөгөөний уялдаа холбоог сайжруулан процессыг автоматжуулж, 7-21 өдрийн ажлыг хагас өдөрт гүйцэтгэх загварчлал боловсруулсан цогц төсөл юм. Энэ хүрээнд бүтээгдэхүүний нөөц, тасалдал үүсэхээс сэргийлсэн шинэ аргачлалыг нэвтрүүлэхийн зэрэгцээ алба хоорондын өгөгдлийн бүтцийг шинэчилж, үйлдвэр, борлуулалтын уялдааг сайжруулж, агуулахын зай, хүн хүчний зохион байгуулалтыг нэтгэсэн загвартай болж буй нь компанийн өгөөж, зардлын хэмнэлтэд өндөр ач холбогдолтой төсөл хэрэгжүүллээ.

“BOOMI- API – Ази, номхон далайн бүс нутгийн сайн туршлагаар нэрлэгдлээ

АПУ компанийн дижитал шилжилт олон улсад инновацлаг сайн туршлагаар нэрлэгдэв. Мэдээллийн технологийн салбарт тэргүүлэгчдийн нэг болох Boomi Official платформын Ази-Номхон далай, Японы (API) бүс нутгийн чуулга уулзалтаар Австралид төвтэй At-tura компанитай хамтран хөгжүүлсэн API платформ технологийн шилдэг инновацаар АПУ компанийн хэрэгжүүлсэн төслийг шалгарууллаа. АПУ компани дотооддоо болон гадагшаа ашигладаг бүхий л тусдаа системүүдийг API технологид суурилан холбож, цаашдын интеграциуд үүгээр дамжуулан маш хялбар холбогдох боломжтой болсноороо онцлог юм. Ингэснээр үйлдвэрлэл, үйл ажиллагаа хурдсаж, өгөгдөл дамжуулалт, бүтээмжийг нэмэгдүүлсэн сайн туршлага болж буй юм.



3 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Хувьцаа эзэмшигчдийн тоо
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид
Хувьцаа эзэмшигчдийн хурал
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ТУЗ-ийн бүрэлдэхүүн
ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан
ТУЗ-ийн дэргэдэх хороод
Аудитын хороо
Дотоод аудит
Эрсдэлийн удирдлага
Нэр дэвшүүлэх хороо
Залгамж халааны бодлого
Цалин урамшууллын хороо
Цалин урамшууллын бодлого

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ


Ногдол ашгийн бодлого
Ногдол ашиг хуваарилалт
КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ
Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт
Кодексийн хэрэгжилтийн үнэлгээ

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


- Оноосон нэр:
АПУ
- Хэлбэр:
Нээлттэй хувьцаат компани
- Регистрийн дугаар:
2702673
- Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:
Монголын Хөрөнгийн бирж
- МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал:
I
- Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг:
1,064,181,553
- Бизнесийн үндсэн үйл ажиллагааны салбар:
 - **Архины үйлдвэрлэл**
 - **Шар айрагны үйлдвэрлэл**
 - **Спиртийн үйлдвэрлэл**
 - **Ундаа, ус, жүүсний үйлдвэрлэл**
 - **Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл**

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Хувьцаа эзэмшигчдийн тоо¹



Хувьцаа эзэмшигчдийн бүтэц²



¹ ҮЦТХТ ХХК-аас гаргасан 2023.12.31-ний өдрийн байдлаарх үнэт цаасны төвлөрлийн судалгааны мэдээлэл

² ҮЦТХТ ХХК-аас гаргасан 2023.12.31-ний өдрийн байдлаарх үнэт цаас эзэмшигчдийн судалгааны мэдээлэл

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид³

Хувьцаа эзэмшигч	2022 оны эцэс		2023 оны эцэс	
	Хувьцааны тоо ширхэг	Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь
1 Шунхлай Холдинг ХХК	596,229,642	56.03	598,230,342	56.22
2 Heineken Asia Pacific Pte Ltd	266,091,981	25.00	266,091,981	25.00
3 Steppe Beverage KFT	115,769,993	10.88	112,264,896	10.55
4 Бусад	86,089,937	8.09	87,808,918	8.25

Өмнөх онтой харьцуулбал нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Steppe Beverage KFT-ийн эзэмшлийн хувь 0.33%-аар буурсан. Харин Шунхлай холдинг ХХК-ийн эзэмшлийн хувьцаа 0.19%-аар нэмэгдсэн нь АПУ ХК-ийн 100 жилийн ойг угтан, Шунхлай группийн 30 жилийн ойн хүрээнд группийн нийт ажилтанд АПУ ХК-ийн хувьцаа эзэмшүүлэхээр зах зээлээс хувьцаа худалдан авсантай холбоотой.

Хувьцаа эзэмшигчдийн хурал

АПУ ХК-ийн эрх барих дээд удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14:00-15:40 цагийн хооронд 92.43%-ийн ирцтэй хуралдаж, дараах шийдвэрүүдийг гаргав:

1. АПУ ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан “АПУ групп компани 2022 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан” гэсэн дүгнэлтийг хуралд оролцож, хүчинтэй санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.
2. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг ТУЗ-ийн дарга 10 сая, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая байхаар хуралд оролцож, хүчинтэй санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 99.99%-ийн саналаар батлав.

³ ҮЦТХТ ХХК-аас гаргасан 2023.12.31-ний өдрийн байдлаарх үнэт цаас эзэмшигчдийн судалгааны мэдээлэл

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт ТУЗ компанийг удирддаг. ТУЗ нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн дотоод дүрэм журамд заасан АПУ ХК-ийн ТУЗ-ийн болон түүний охин, хараат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлдэг.

ТУЗ-ийн бүрэлдэхүүн

Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 29-ний өдрийн хурлаар 3 жилийн хугацаатай сонгосон ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.



ПҮРЭВИЙН БАТСАЙХАН
ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга

Инженер мэргэжилтэй
Шунхлай холдинг ХХК-ийн Ерөнхийлөгч
2002 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга
Хувьцаа эзэмшил: 0.01%



БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР
ТУЗ-ийн ердийн гишүүн

Эдийн засагч мэргэжилтэй
Монгол Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга
Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал
2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.01%



СЕРГЕЙ ГРОМОВ
ТУЗ-ийн ердийн гишүүн

Инженер мэргэжилтэй
Монгол Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга
2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



КЕННЕТ ЧУ
ТУЗ-ийн ердийн гишүүн

Ниглан бодогч, менежмент мэргэжилтэй
Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийг хариуцсан Гүйцэтгэх захирал
2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



СЭН И-ИН
ТУЗ-ийн ердийн гишүүн

Хуульч мэргэжилтэй
Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийн Хууль эрхзүй хариуцсан захирал
2020 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



ДОРЖИЙН МИЕЭГОМБО
ТУЗ-ийн ердийн гишүүн

Хуульч мэргэжилтэй
“ЕС” ХХН-д зөвлөх
2022 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



ЁНДОН-ОЙДОВЫН ГЭРЭЛЧУЛУУН
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Эдийн засагч мэргэжилтэй
Нээлттэй хот ТББ-ын үүсгэн байгуулагч
2017 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



Одончимэдийн ОДБАЯР
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Багш, эрх зүйч мэргэжилтэй
Ард даатгал ХК, Ард холдинг ХХК, Монгол шуудан ХК-үүдийн ТУЗ-ийн гишүүн
2021 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Эдийн засагч мэргэжилтэй
2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



ЧАДРААБАЛЫН АРИУНСАН
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан

ТУЗ нь танхимаар, танхим-цахим хосолсон, эчнээ санал хураалтын хэлбэрээр нийт 14 удаа, дунджаар 98%-ийн ирцтэй хуралдаж, бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 55 тогтоол гаргав.

Д/д	Огноо	Ирц	Нийт	Баталсан тогтоолын тоо										
				АПУ ХК	АПУ Дэйри ХХК	АПУ Трейдинг ХХК	М Би Си Азия Пасифик ХХК	СББ Трейд ХХК	Спирт бал бурам ХХК	ОХУ-ын Гранд ХХК	ОХУ-ын Гранд Ист ХХК	БНХАУ ӨМӨЗО-ны Эйпиюу трейд ХХК		
				ТУЗ-ийн хурал	Хувьцаа эзэмшигчдийн хурал									
1	2023.01.24	100%	1	1										
2	2023.02.13	100%	12	3	2	1	1	1	1	1	1	1	1	
3	2023.03.17	100%	1	1										
4	2023.03.28	89%	5	1	3				1					
5	2023.04.28	100%	1	1										
6	2023.05.24	100%	1	1										
7	2023.07.04	100%	4	1	2		1							
8	2023.08.09	100%	5	4	1									
9	2023.09.05	100%	1	1										
10	2023.09.21	100%	1		1									
11	2023.10.06	100%	1		1									
12	2023.11.13	100%	9	3	2	1	1	1	1					
13	2023.12.05	89%	12	3	2	1	1	1	1	1	1	1	1	
14	2023.12.22	100%	1	1										
Нийт		98%	55	21	14	3	4	3	4	2	2	2	2	

Жилийн турш ТУЗ-ийн гишүүн бүрийн хуралд оролцсон ирц:

П.Батсайхан	100%
Б.Батбаяр	100%
Сергей Громов	100%
Кеннет Чу	100%
Сэн И-Ин	100%
Д.Миеэгомбо	93%
Ё.Гэрэлчулуун	100%
О.Одбаяр	93%
Ж.Үнэнбат	100%

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Компанийн тухай хуулийн 81.2-т заасны дагуу ТУЗ-ийн дэргэд Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо ажилладаг бөгөөд хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн юм.

АУДИТЫН ХОРОО

Бүрэлдэхүүн	ТУЗ-ийн гишүүний хэлбэр	Нэрс
Хорооны дарга	Хараат бус гишүүн	Ж.Үнэнбат
Гишүүд	Ердийн гишүүн	Сэн И-Ин
	Хараат бус гишүүн	О.Одбаяр

Тайлант хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны журмыг ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын 24-ний өдрийн хурлаар шинэчлэн баталсан.

Аудитын хороо нь 3 удаа, тус бүр 100%-ийн ирцтэйгээр хуралдаж, дараах асуудлаар санал, зөвлөмж, шийдвэр гаргаж ТУЗ-д танилцуулж, батлууллаа. Үүнд:

1. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны журам, Дотоод аудитын бодлого, Эрсдэлийн удирдлагын бодлого, Дотоод хяналтын бодлогын шинэчилсэн найруулгуудыг ТУЗ-д танилцуулж, батлуулах
1. Групп компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын байгууллагын дүгнэлттэй танилцах,
1. Групп компанийн хэмжээнд 2023 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллага болон аудитын ажлын хөлсний хэмжээг ТУЗ-д санал болгох.

ДОТООД АУДИТ

Дотоод аудитын бодлого

Дотоод аудитын бодлогыг ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын 24-ний өдрийн хурлаар шинэчлэн батлав.

Дотоод аудит нь Компанийн үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бие даасан, бодитойгоор баталгаа өгөх зөвлөх үйл ажиллагаа юм.

- Компанийн засаглалын үйл явцыг үнэлж, сайжруулах зөвлөмж өгөх;
- Эрсдэлийн удирдлагын үйл явцын үр нөлөөтэй ба үр ашигтай байдлыг үнэлэх сайжруулах;
- Дотоод хяналтын системийн үр нөлөөтэй ба үр ашигтай байдалд үнэлгээ хийх, баталгаа гаргах;


ТУЗ-ийн дэргэдэх хороод Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, хороодын журамд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллав.

- Компанийн санхүүгийн үйл ажиллагаа нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн, мөрдөж буй заавар, журмын дагуу үнэн зөв тайлагнаж буй эсэхэд баталгаажуулалт өгөх;
- Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, бизнесийн болон бусад мэргэжлийн ёс зүйн дүрэм, олон улсын болон дотоодын стандарт шаардлага, нормын мөрдөлт тэдгээрийн хэрэгжилтэд баталгаажуулалт хийх;
- Компанийн хөрөнгө хамгаалалт болон хөрөнгийн зүй зохистой ашиглалтад баталгаажуулалт хийх, залилан мэхлэлт, шамшигдуулалт, хувийн ашиг сонирхлын шинжтэй аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, зөвлөмжөөр хангах

Дотоод аудитыг гүйцэтгэхэд аудиторуд компанийн бизнесийн ёс зүйн дүрэм болон Дотоод Аудиторын Олон Улсын Институтээс гаргасан ёс зүйн дүрэм, мэргэжлийн ёс зүйг баримтлахаас гадна дараах зарчмыг баримтална. Үүнд:

- шударга байх,
- бодитой байх,
- Хараат бус, бие даасан байдлыг хангах
- нууц хадгалах,
- мэргэжлийн мэдлэг, ур чадвартай байх.

Дотоод аудитын бүтэц



Дотоод аудитын бүтэцэд өөрчлөлт гараагүй.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлагын бодлого

Эрсдэлийн удирдлагын бодлогыг ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын 24-ний өдрийн хурлаар шинэчлэн баталсан. Тус бодлогоор эрсдэл гэдэгт компани зорилго, зорилтдоо хүрэхэд учрах тодорхой бус байдал, үр дагавар, гарз хохирлыг ойлгоно. Компанийн эрсдэлийн удирдлагын үйл явц нь эрсдэлийг тодорхойлж бүртгэх, эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг удирдах гэсэн үндсэн гурван үе шатыг хамарна. Эрсдэлийг эх үүсвэрээс нь хамааруулан гадаад, дотоод эрсдэл, үр дагавраас хамааруулан стратегийн, санхүүгийн, үйл ажиллагааны, комплайнсын, бусад эрсдэл хэмээн ангилдаг.

Эрсдэлийн мэдээлэл

АПУ ХК нь байгаль орчин, нийгэм, эдийн засагт ээлтэй засаглалыг бэхжүүлэхэд чиглэн ажиллаж байна. Үүний тулд бид эрсдэлийн удирдлагын шинэ чиг хандлага болох тогтвортой хөгжилд чиглэсэн эрсдэлийн удирдлагын соёлыг түгээн дэлгэрүүлэхэд ихээхэн анхаарч, аливаа болзошгүй эрсдэл, тодорхойгүй нөхцөл байдлыг урт хугацаандаа оновчтой удирдах, шинэ боломжуудыг эрэлхийлэн ажилласаар ирлээ.

Ирэх жилүүдэд дэлхий дахинд төдийгүй манай салбарын үйл ажиллагаанд шууд болон дам байдлаар нөлөөлөх дараах таван чиглэлийн эрсдэлийг бид онцолж байна. Үүнд байгаль цаг уурын өөрчлөлт, хүлэмжийн хийн асуудлууд, геополитикийн зөрчилдөөн, үүнээс үүдсэн эдийн засгийн тодорхойгүй байдал, шинэчилсэн хуулийн шаардлагууд, болон мэдээллийн оновчтой бус урсгалын нөлөөллүүд багтана.

Нэг нь нөгөөгөөсөө харилцан уялдаа холбоотойгоор орших эдгээр эрсдэлүүд нь бидний бизнесийн үйл ажиллагаанд цогцоороо томоохон сорилтуудыг дагуулж байна. Ялангуяа байгаль цаг уурын өөрчлөлт нь зарим бүс нутагт их хэмжээний хур тунадас, үерийн аюул дагуулж байгаа бол өөр нэг хэсэгт ган зуд болох эрсдэлийг учруулснаар хөрсний гулгалт, элэгдэл үүсэх, гал түймэр гарах зэргээр экосистемийн олон талт байдалд дам байдлаар, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд шууд байдлаар нөлөөлсөн үйл явдлууд өнгөрсөн онд ихээхэн тохиолдсон.

Харин урт хугацаандаа хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй эрсдэлүүд, түүн дотроо хүлэмжийн хийн ялгарал нэмэгдэх эрсдэл нь бидний хүрээлэн буй орчинд илүү ноцтой нөлөөллийг авчрах магадлалтай тул эдгээр асуудлын суурь шалтгаануудад АПУ ХК онцгой анхаарал хандуулж тогтвортой хөгжлийн

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:


- Соёлыг түгээх,
- Үнэ цэнийг бүтээх,
- Шийдвэр гаргалтад ашиглагдах,
- Мэдээлэлтэй, ил тод байх,
- Тасралтгүй байх.

зорилго, зорилтууддаа тусган, зохистой хариу арга хэмжээг төлөвлөж, шаардлагатай төсөл хөтөлбөрүүдийг санаачлан эхлүүлээд байна.

Тухайлбал: CO2 бууруулах уурын зуухны төсөл, Саарал усны хаягдлыг дахин ашиглах төсөл, Монгол бяслаг, Шигүдэри урлах үйлдвэрийн хүлэмжийн хийг бууруулах шийдлүүд, Хог хаягдлын 3R стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг дурдаж болно. Мөн бид санхүү, зардлын ухаалаг хэмнэлтийг сахин биелүүлж, урт хугацааны мөнгөн хөрөнгийн төлөвлөлттэй уялдуулан валютын форвард, своп хэлцлүүд хийн, багц бүтээгдэхүүний оновчлолыг сайжруулах замаар үйлдвэрлэлийн тасалдлаас урьдчилан сэргийлж бизнесийн ашигт ажиллагааг ханган үнэ цэнийг түгээж чадсан.

Харин дотоод эх үүсвэртэй эрсдэлүүдийн хувьд стратеги, үйл ажиллагаа, санхүү, нийцлийн үр дагавраас хамааруулан холбогдох алба нэгжүүдийн оролцоотойгоор эрсдэлүүдийг тодорхойлж, тэдгээрт нарийвчилсан дүн шинжилгээ хийн, эрсдэлийг оновчтой үнэлж, зэрэглэн, зохимжит түвшинд эрсдэлийг барих, эрсдэлийг бууруулах ажлын гүйцэтгэлийн түвшинд мөшгөлт хийх замаар эрсдэлийг удирдан ажиллаж байна.

ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛСИЙН НӨЛӨӨЛӨЛ БА ТОМООХОН ЭРСДЭЛҮҮД



Цаг уурын өөрчлөлт, байгалийн давтагдашгүй хүчин зүйл	Эдийн засгийн тодорхойгүй байдал, ашиг орлого	Шинэчилсэн хуулийн шаардлага, нийцэл	Геополитикийн сэргэлдөөн	Мэдээллийн оновчтой бус урсгал, нэр хүндийн эрсдэл

★ Боломж ⦿ Дам нөлөө ○ Шууд нөлөө

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

Бүрэлдэхүүн	ТУЗ-ийн гишүүний хэлбэр	Нэрс
Хорооны дарга	Хараат бус гишүүн	О.Одбаяр
Гишүүд	Ердийн гишүүн	П.Батсайхан
	Хараат бус гишүүн	Ё.Гэрэлчулуун

Тайлант хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны журмыг ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын 24-ний өдрийн хурлаар шинэчлэн баталсан.

Нэр дэвшүүлэх хороо 1 удаа 100%-ийн ирцтэйгээр хуралдаж, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны журам, Залгамж халааны бодлогын шинэчилсэн найруулгуудыг ТУЗ-д танилцуулж, батлуулах шийдвэр гаргав.

Залгамж халааны бодлого

Залгамж халааны бодлогыг ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын 24-ний өдрийн хурлаар шинэчлэн баталсан ба ингэхдээ бодлогын цар хүрээг хумьж, зөвхөн ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, сонгох, залгамж халааг бэлтгэх, сургаж хөгжүүлэх, гүйцэтгэлийг үнэлэх харилцааг зохицуулахаар заасан.

Залгамж халааны бодлогод Нэр дэвшүүлэх хорооноос ТУЗ-ийн гишүүний албан тушаалд тохирох этгээдийг олж тодорхойлох хэлбэр, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур, шаардлага, сонгон шалгаруулалтын зарчим, нэр дэвшигчдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхэд мөрдөх журам хийгээд ТУЗ-ийн гишүүний сургалт, хөгжил, гүйцэтгэлийн үнэлгээ зэрэг асуудлыг тусган шинэчлэв.

ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО

Бүрэлдэхүүн	ТУЗ-ийн гишүүний хэлбэр	Нэрс
Хорооны дарга	Хараат бус гишүүн	Ё.Гэрэлчулуун
Гишүүд	Ердийн гишүүн	Ж.Үнэнбат
	Хараат бус гишүүн	Кеннет Чу

Тайлант хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.

ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны журмыг ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын 24-ний өдрийн хурлаар шинэчлэн баталсан.

Цалин урамшууллын хороо 1 удаа 100%-ийн ирцтэйгээр хуралдаж, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны журам, Цалин урамшууллын бодлогын шинэчилсэн найруулгуудыг ТУЗ-д танилцуулж, батлуулах шийдвэр гаргав.

Цалин урамшууллын бодлого

Цалин урамшууллын бодлогыг ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын 24-ний өдрийн хурлаар шинэчлэн баталсан бөгөөд тус бодлого нь Компанийн хэмжээнд баримтлах цалин хөлс, урамшууллын зарчмыг тодорхойлж, ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд, нийт ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтолцооны үндсийг тогтооход чиглэгдэнэ.

Компани нь өөрийн цалин урамшууллын тогтолцоонд дараах суурь зарчмыг баримтална.

Үүнд:

- Principle of External Equity: Зах зээлд өрсөлдөхүйц цалин урамшууллын тогтолцоогоор дамжуулан мэргэшсэн, өндөр ур чадвартай ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах;
- Principle of Internal Equity: Ижил үнэлэмж бүхий хөдөлмөрт адил цалин, урамшуулал олгох, гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан цалин урамшууллын хуваарилалт аливаа ялгаварлал, гадуурхал, тэгш бус байдлаас ангид байх;
- Principle of Individual Worth: Цалин урамшууллыг ажилтны мэдлэг, ур чадвар болон ажлын байрны үнэлгээ, үнэ цэнд суурилж тогтоох.

ТУЗ-ийн цалин, урамшуулал

Цалин урамшууллын бодлогод ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталж, гүйцэтгэлийг Компанийн жилийн тайланд тодорхой тусгахаар заасан.

ТУЗ-ийн дарга болон гишүүдэд сар бүр тогтмол цалин олгодог ба нэмэлт урамшуулал олгодоггүй. 2023 онд ТУЗ-ийн цалин, урамшууллын хэмжээнд өөрчлөлт ороогүй.

ТУЗ-ийн гишүүдэд 2023 онд олгосон цалин, урамшуулал

	ТУЗ-ийн гишүүн	Сарын үндсэн цалин (төг)	Олговол зохих нийт цалин (төг)	НДШ, ХХОАТ суутгал (төг)	Гарт олгосон нийт цалин
1	П.Батсайхан	10,000,000	120,000,000	18,712,200	101,287,800
2	Б.Батбаяр	6,500,000	78,000,000	14,512,200	63,487,800
3	Сергей Громов	6,500,000	78,000,000	14,512,200	63,487,800
4	Кеннет Чу	6,500,000	78,000,000	23,190,000	54,810,000
5	Сэн И-Ин	6,500,000	78,000,000	23,190,000	54,810,000
6	Д.Миеэгомбо	6,500,000	78,000,000	14,512,200	63,487,800
7	Ё.Гэрэлчулуун	6,500,000	78,000,000	13,324,200	64,675,800
8	Ж.Үнэнбат	6,500,000	78,000,000	14,512,200	63,487,800
9	О.Одбаяр	6,500,000	78,000,000	14,512,200	63,487,800
	НИЙТ	62,000,000	744,000,000	150,977,400	593,022,600

Кодексийн шаардлагын дагуу 2022 оноос хойш ТУЗ-ийн цалингийн мэдээллийг нээлттэй, ил тод танилцуулж байна.

Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал

Цалин урамшууллын бодлогод Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал үндсэн цалин, урамшууллаас бүрдэж, ТУЗ-тэй байгуулсан гэрээгээр тодорхойлогдохоор заасан. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал (хувь хүн) хэрэгжүүлдэг. Гүйцэтгэх захирлыг сонгох, чөлөөлөх, бүрэн эрхийг тогтоох, түүнтэй байгуулах гэрээний нөхцөл, цалин, шагнал урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох нь ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарна. АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал нь Компанийн охин компаниуд болох АПУ Трейдинг ХХК,

М Би Си Азиа Пасифик ХХК, СББ Трейд ХХК, Спирт бал бурам ХХК, ӨМӨЗО-ны Эйпию Трейд ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар давхар томилогдон ажилладаг. Гүйцэтгэх захиралд ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан үндсэн цалингаас гадна “борлуулалтын орлого”, “хүү, татварын өмнөх ашиг”, “зардлын хэмнэлт”, “хүн ба байгууллагын хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл болон байгууллагын соёлыг сайжруулах ажлуудын үр дүн” гэсэн гүйцэтгэлийн 4 үндсэн шалгуур үзүүлэлтийг ижил хувийн жинтэйгээр тооцож, урамшуулал олгодог.

Компанийн ажилтны цалин, урамшуулал

Цалин урамшууллын бодлогод Компанийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд болон нийт

ажилтны цалин, урамшууллыг Гүйцэтгэх захирал тогтоохоор заасан.

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

АПУ ХК-ийн гаргасан нийт хувьцаа	1,064,181,553
Халаасны хувьцаа	1,206,810
Эргэлтэд буй хувьцаа	1,062,974,743

Компанийн зах зээлийн үнэлгээ 2023 оны эцэст 1 их наяд 287 тэрбум төгрөг байснаар өмнөх оны мөн үеэс 298 тэрбум төгрөгөөр буурч, зах зээлийн үнэлгээгээр тэргүүлэгч Хаан банк, Худалдаа хөгжлийн банкны араас гуравдугаарт жагслаа.

Тайлант хугацаанд Компанийн 14 сая ширхэг үнэт цаас нийт 16.3 тэрбум төгрөгөөр арилжигдсанаар үнийн дүнгийн эрэмбээр гуравдугаарт, тоо хэмжээний эрэмбээр 14-т жагсжээ.

Хувьцааны хаалтын ханш:

- дунджаар 1,275 төг,
- хамгийн ихдээ 1,499 төг (2023.01.12-ны өдөр),
- хамгийн багадаа 1,225 төг (2023.08.08-ны өдөр) байв.



АПУ ХК-ийн хувьцаа эзэмшигч Монгол Улсын хувийн хэвшлийн анхдагчдын нэг Шунхлай Групп 30 жилийн ойгоо тохиолдуулан групп компанийн нийт 7500 ажилтандаа талархал илэрхийлж, АПУ ХК-ийн хувьцаа эзэмших эрх олгох шийдвэр гаргасан.

Уг шийдвэрийн хүрээнд, АПУ ХК-ийн 100 жилийн ойг угтан Компанийн ТУЗ-өөс 2023 оны 12-р сарын 05-ны өдөр АПУ ХК-ийн 1,206,810 ширхэг халаасны хувьцааг дахин гаргах замаар “Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр”-ийг баталсныг Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх)-ноос зөвшөөрч, халаасны хувьцааг гүйлгээнд гаргаж, хаалттай хүрээнд ажилтнуудад эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн болно.

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

Ногдол ашгийн бодлого

Ногдол ашгийн бодлогыг ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын 24-ний өдрийн хурлаар шинэчлэн баталсан бөгөөд тус бодлогоор Компани нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай удирдаж, нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээг тогтвортой байлгах зарчим баримталдаг.

Компани дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна. Үүнд:

- Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх,
- Ногдол ашиг төлсний дараа Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс их байх,
- Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.


Ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг ТУЗ гаргах ба санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор, хагас жилээр ногдол ашиг хуваарилах тохиолдолд хагас жилийн санхүүгийн тайлан гарснаас хойш 30 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ.

ТУЗ нь ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэвэл энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн хуралд заавал тайлагнана.

Ногдол ашиг хуваарилалт

АПУ ХК-ийн ТУЗ-өөс 2023 оны нийлбэр дүнгээр компанийн хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд нийт 89 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн болно.

Тайлант хугацаа	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг)	ТУЗ-өөс ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн өдөр	Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр
2019 он	71	2020.02.14	2020.03.23
2020 он	95		
Үүнээс: I хагас жил	37.5	2020.08.13	2020.09.02
II хагас жил	57.5	2021.02.15	2021.03.31
2021 он	106		
Үүнээс: I хагас жил	46	2021.08.16	2021.09.03
II хагас жил	60	2022.02.17	2021.04.08
2022 он	89		
Үүнээс: I хагас жил	45	2022.08.03	2022.08.22
II хагас жил	44	2023.02.13	2023.04.07
2023 он	89		
Үүнээс: I хагас жил	45	2023.08.09	2023.08.28
II хагас жил	44	2024.02.16	2024.04.12



Ногдол ашгийн төлбөрийг нийт хувьцааны таваас доош хувийг эзэмшигчдэд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан, таваас дээш хувийг эзэмшигчдэд компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгож байна.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ, ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт

СЗХ-ны 2022.03.23-ны өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс” (цаашид “Кодекс гэх”) -ийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд компанийн засаглалын дараах 18 бодлого, дүрэм журам, зааврыг үе шаттайгаар Кодексийн зарчимд нийцүүлэн шинээр болон шинэчлэн батлахаар төлөвлөн, 2023 оны эцсийн байдлаар хэрэгжилт дараах байдалтай байна:

Д/д	Баримт бичгийн нэр	Батлах хэлбэр	Хэрэгжилт
А	Дүрэм, бодлогын баримт бичиг, заавар болон бусад:		
1.	Бизнесийн ёс зүйн дүрэм	Шинээр баталсан	Хэрэгжсэн
2.	Залгамж халааны бодлого	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
3.	Цалин, урамшууллын бодлого	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
4.	Ногдол ашгийн бодлого	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
5.	Эрсдэлийн удирдлагын бодлого	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
6.	Дотоод аудитын бодлого	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
7.	Дотоод хяналтын бодлого	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
8.	Комплайнсын хяналтын бодлого/заавар	Шинээр баталсан	Хэрэгжсэн
9.	Тогтвортой хөгжлийн бодлого	Шинээр батлах	Боловсруулж байна
10.	Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого	Шинээр баталсан	Хэрэгжсэн
Б	Дотоод журам:		
11.	Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
12.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
13.	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
14.	ТУЗ-ийн дэргэдэх хороод (Аудит, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх)-ын журам	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
15.	Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журам	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
16.	Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
17.	Дотоод хяналт, комплайнс, дотоод аудитын нэгж эсхүл ажилтны үйл ажиллагааны журам	Шинээр батлах	Боловсруулж байна
18.	Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам	Шинээр батлах	Боловсруулж байна

Кодексийн хэрэгжилтийн үнэлгээ

Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2022.06.09-ний өдрийн А/58 тушаалаар баталсан аргачлалын дагуу АПУ ХК-аас Кодексийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээг 2023 онд хоёр удаа хийсэн ба СЗХ-ны Компанийн засаглал, комплайнсын хэлтсээс тухай бүр хянан баталгаажуулсан үр дүнг дор үзүүлэв.

АПУ ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	2023 оны I хагас жил		2023 оны эцэс	
			Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	11	92%	10	83%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%	10	100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	4	67%	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	7	88%	7	88%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%	6	100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%	8	100%
8	Компанийн соёл	6	5	83%	5	83%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	8	80%	9	90%
Нэгдсэн дүн		72	65	90%	67	93%
			Засаглал хэвийн буюу эрсдэлгүй		Засаглал хэвийн буюу эрсдэлгүй	

АПУ ХК кодексийн хэрэгжилтийн үнэлгээгээр Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниудаас 2023 оны эхний хагас жилд 90%-ын үнэлгээгээр 7-р байранд, 2023 оны эцэст 93%-ийн үнэлгээгээр 4-р байранд тус тус эрэмбэлэгдлээ.

04 ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Тогтвортой түнш
Ямагт орших өв соёл
Ногоон ба цэвэр тунгалаг
Хүчирхэгжсэн хамт олон
Баялаг, Хариуцлагатай



ХАМТРАН БҮТЭЭХ ТОГТВОРТОЙ ИРЭЭДҮЙ

АПУ ХК-ийн Тогтвортой хөгжлийн стратеги

Бид 2023 онд Стратеги, тогтвортой хөгжлийн олон улсын зөвлөх үйлчилгээний "Fronteer" байгууллагатай хамтран ажиллаж "Тогтвортой хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичиг" боловсруулах төслийг хэрэгжүүлж, тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойллоо. Ирэх 100 жилдээ АПУ ХК эх дэлхий болон Монгол улсдаа ямар чиглэлээр хөрөнгө оруулалт, эерэг үр нөлөө, үнэ цэнийг бүтээхээ тодорхойлохын тулд бид бүхий л тогтвортой хөгжлийн төсөл, хөтөлбөрүүд болон зорилтуудыг нэгтгэн системчилж 5 ханат НӨЛӨӨЛЛИЙН ГЭР модел-ийн дагуу "Бахархалт Монгол" Тогтвортой хөгжлийн стратеги 2030-ыг боловсруулаад байна.



Тогтвортой амьдралын хэв маяг, байгалийн хэмнэлтэй уялдах аж ахуй нь Монгол түмэнд шинэ ойлголт биш юм. Монгол гэрийн дугуй



бүтэц, Монгол гутлын хавтгай ул зэрэг нь бидэнд өвлөж ирсэн уламжлалт технологи бүр байгаль эхдээ үл мөр үлдээхгүй, үргэлж хувьсаж буй амьдралын мөчлөгтэй уялдаж урагшлах замыг заасан байдаг. Энэхүү үнэт зааврыг бид эрхэмлэж, бүхий л үйл ажиллагаа,

инновацдаа шингээн ирсэн. Цаашид ч энэ өв соёлыг өвлүүлэн үлдээх нь Монгол улсын зах зээлд томоохон байр суурь эзэлж, олон мянган ажилтан, хэрэглэгч, хамтрагчдын өдөр тутмын түнш байж, эергээр нөлөөлөх боломжийг атгалцаж буй бидний үүрэг юм.

Дунд хугацаанд буюу 2030 он хүртэл бүх үйл ажиллагаагаа "Бахархалтайгаар Монгол байх" агуулгад чиглүүлж, жинхэнэ Монгол мөнчанаарыг дэлхийд үнэлүүлэх, бодит ажил, бодит бизнесийн шийдвэрүүдээр дэмжих суурийг бүрдүүлэхээр бид зорьж байна.



ТОГТВОРТОЙ ТҮНШ

НҮБ БОЛОН ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Зуу дахь жилийн босгоо давж буй АПУ ХК-д байгууллага доторх засаглалаа дээд түвшинд барихтай зэрэгцэн бүх хамтран ажиллаж буй хамтрагч, харилцагч, хэрэглэгч нартаа ТОГТВОРТОЙ, жишиг ТҮНШ байх нь эн тэнцүү чухал.

Энэ ч утгаараа 2023 онд бид НҮБ-ын Тогтвортой хөгжлийн чуулганыг дэмжин ажиллаж, **“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХӨТЛӨГДСӨН БИЗНЕСИЙГ ХАМТРАН БҮТЭЭХ НЬ”** сэдвийн дагуу салбарын тогтвортой хөгжлийг хамтран бүтээх зорилгын хүрээнд бодитоор хэрэгжүүлсэн сайн туршлагаудаа хуваалцаж, үйлдлээрээ нэгдэхийг бүх оролцогч талд уриаллаа. Бид өөрийн ханган нийлүүлэх сүлжээнд нэмүү өртгийг жигд тарааж, сүү бэлтгэн нийлүүлэгчид, тариаланчдын орлогыг өсгөх, цаашлаад орон нутгийн хөгжлийг хурдасгах, хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг сааруулах, импортыг орлох, экспортын боломжийг нээх зэрэг тогтолцооны өөрчлөлтүүдийг хийсээр байгааг бизнесийн салбарын сайн жишиг болгон үргэлжлүүлэн ажиллах юм.

НҮБ-ын Суурин зохицуулагч



Тапан Мишра болон багийн гишүүдтэй АПУ ХК-ийн удирдлагын баг мөн уулзаж орон нутагт нэмүү өртөг шингээсэн үйлдвэрлэлийг үе шаттайгаар байгуулж буй талаар мэдээлэл өгч ярилцсан. Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх, амьдралын чанарыг сайжруулах, тогтмол орлогын эх үүсвэрийг бий болгох тогтвортой хөгжлийн томоохон ач холбогдолтой ажлуудаа бид баяртайгаар хуваалцлаа. Цаашид сүүний салбарыг сүү бэлтгэн



Зорилго:

“Монголын нээлттэй хувьцаат компаниудын дунд байгаль орчин, нийгэм, засаглалын нөлөөллөөрөө жишиг байгууллага байна.”

нийлүүлэгчид, хувийн хэвшил, төр, олон улсын байгууллагууд болон бусад оролцогч талууд хамтран хөгжүүлэх олон боломж, хамтын ажиллагааг нэмж хэлэлцсэн. Эдгээр ажлууд хүнсний аюулгүй, тогтвортой байдлыг хангах, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах бөгөөд НҮБ-ын Суурин Зохицуулагч бүрэн дэмжиж ажиллахаа мэдэгдсэнд бид маш их баяртай байна.

ТОС ХОЛБООНЫ БОНЗ-ЫН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

Тогтвортой санхүүгийн (ТоС) Холбоо нь гишүүн байгууллагуудын тогтвортой хөгжлийн стратеги, засаглал, дотоод үйл ажиллагаа, болон тайлагналыг хөгжүүлж, бэхжүүлэхэд чиглэж ажиллах “Тогтвортой байдал, байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын удирдлага хариуцсан мэргэжлийн зөвлөл”-ийг шинээр үүсгэн байгуулсан. Энэхүү зөвлөлийн анхны гишүүдийн нэгээр АПУ ХК санхүүгийн бус бизнесийн салбарыг төлөөлөн нэгдсэн нь 2023 оны онцлох үйл явдал, чухал хамтын ажиллагааны эхлэл байлаа. Үйлдвэрлэлийн, тэр дундаа шингэн хүнсний салбар дундын сорилт, шийдлүүдэд БОНЗ-ын зарчмуудыг баримтлан эерэг нөлөөлөл үзүүлэх, нэг байгууллага бус салбараараа хамтран хөгжих, хөдлөх талаар ТоС Холбооны хамт олонтой ээлж дараалан хуваалцаж, боломжит байдлаар хамтран ажиллалаа.



Жилийн эхэнд АПУ ХК анх удаа Тогтвортой хөгжлийн тайлангаа тусгайлан гаргасан бөгөөд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг томоохон байгууллагууд хамтран гаргасан удирдамжийн дагуу 2022 оны БОНЗ-ын тайлагналаа мөн сайн дураар гүйцэтгэсэн. Холбооноос 11-р сард зохион байгуулсан Сингапурын шилдэг БОНЗ-ын туршлагаудтай танилцах аялалд АПУ ХК-ийн төлөөлөл оролцсон нь ТУЗ болон хамт олныг олон улсын мэдээлэл, цаг үеийн тогтвортой хөгжлийн мэдээллээр хангах томоохон боломж болж өгсөн. Бид үргэлжлүүлэн тогтмол хамтран ажиллаж, тогтвортой хөдөө аж ахуйд олон талын оролцоог хангаж, үр дүн өндөртэй ажлуудыг хамтран гүйцэтгэнэ гэдэгт итгэлтэй байна. Өрсөлдөх бус хамтран бүтээх зарчмыг бодит ажил болгож, манлайлж яваа ТоС Холбооны хамт олонд талархлаа илэрхийлье.



ЯМАГТ ОРШИХ ӨВ СОЁЛ

Зорилго:

“Монголын гайхамшигт өв соёлыг ямагт амьд байлгаж, хойч үедээ өвлүүлэн үлдээхэд АПУ ХК өөрийн бизнес, хэлхээ холбоо, нөөц боломжоо бүрэн ашиглана.”

“ӨВ СОЁЛООР ГОЁНО” АЛТАЙН ЯТГА

1400 жилээс улбаатай соёлын гайхамшигтай үнэт өвөө өвлүүлэн үлдээх зорилготой “Алтайн ятга” хөгжмийн зэмсгийг олонд таниулах ажлыг Соёлоор Гоёно төслийнхөө хүрээнд хийж хэрэгжүүлээ.

Энэхүү өв соёлын билэгдлийг үрхойчдоо өвлүүлэх зорилгоор гурван ширхэг Алтайн ятга хөгжмийн зэмсгийг СТА Д.Ганпүрэвээр урлуулан Өнөр бүл асрамжийн газрын хүүхдүүдэд хандивлав. Алтайн ятга хэмээх эртний хөгжмийн зэмсгийн уянгалаг аялгууг уртын дуу, орчин үеийн Регги урлагтай холбон үр хойчдоо өвлүүлэхээр Соёлоор гоёно төслийн хүрээнд Алтайн ятга нэвтрүүлэг, “ТААТАЙ ЯА” дуу бүтээж олон нийтийн сонорт хүргэв.

ҮНДЭСНИЙ ИХ ӨВ СОЁЛООР ГОЁНО



АПУ ХК нь үндэсний бөхийн спортыг дэмжих замаар өв соёлоо түгээн дэлгэрүүлэх зорилгоор Монгол Улсын Арслан Б.Орхонбаяр, Монгол Улсын Харцага Т.Өсөх-Ирээдүй нартай урт хугацаанд хамтран ажиллахаар боллоо. Бид уламжлал, өв соёлоо эрхэмлэн дээдэлж үндэсний спортууд болох шагайн харваа, сур харваа, хурдан морь, үндэсний бөх тэргүүтэй олон төрөлд бахархал болсон тэргүүлэх тамирчидтай хамтран ажиллаж байна.



“НОГООН ДАДАЛТ МАЛЧИД” МЭДЛЭГЖИХ АЯН

Хүнсний аюулгүй байдал, хангамжийг тогтолцоогоор нь сайжруулах үндэсний хөдөлгөөний хүрээнд “Ногоон Дадалт Малчид” Мэдлэгжих Аяныг эхлүүллээ. Стратегийн онцгой хүнс болсон сүүний чанар, АПУ ХК-ийн сүү бэлтгэн нийлүүлэлтийг түүчээлэн ажиллаж буй Зүүнхараа дахь малчид маань аяны эхний арга хэмжээнд оролцсон юм. Ингэснээр анхан шатны үйлдвэрлэгч буюу малчдын дунд Хөдөө аж ахуйн зохистой дадлыг хэвшүүлэх, баталгаажсан органик Монгол хүнс бэлтгэх замын зургийг мэргэжлийн

байгууллагуудтай хамтран танилцуулж, өрхийн боловсрол, санхүүгийн ногоон, малчдад чиглэсэн санхүүгийн хүртээмжийг цахим платформуудаар дамжуулан ойртуулах зэрэг салбарын цаг үеийн боломж, хандлагыг хэрэгжүүлэн ажиллахаар зорьж байна. МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хувьсгал аяныг дэмжин АПУ ХК ЦАГААН ХУВЬСГАЛ уриалгыг гарган ажиллаж, сүүний салбар, тэр дундаа анхан шатны боловсруулах үйлдвэрлэлийг бэлтгэн нийлүүлэгчдэд ойртуулах,



орлогыг нь тогтмолжуулах байдлаар сүүний салбарыг стандартжуулах зорилгоор “Монгол Сарлаг” төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Ирэх 2024 онд төслийн оролцогч өрхүүд тус аянд нэгдэх юм.



МАЛЧИД, ФЕРМЕРҮҮДИЙН АМЬЖИРГААГ ДЭМЖИХ

АПУ ДЭЙРИ Монгол сүүний үйлдвэр нь малчид фермерүүдийн тогтвортой амьжиргааг дэмжих хүрээнд цаг уурын хэцүү нөхцөл байдал, өвөлжилтийн хүндрэлтэй цаг үед шингэн сүүг өндөр үнээр авч, нэн шаардлагатай байгаа 150 гаруй тонн малын тэжээлээр хангалаа.



НОГООН БА ЦЭВЭР ТУНГАЛАГ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮД

АПУ ХК нь “Дэлхийн Усны өдөр 2023”-ыг тохиолдуулан Эко Орчин ХХК, Мультипак ХХК, “Бичил нахиа”, “Хаягдал хувцсаа үнэ цэнэ болгоё” төслийн багтай хамтран “Эх Дэлхийгээ Хайрлаж, Усаа хэмнэе!” өдөрлөгийг нийт компанийн ажилтнуудын дунд уламжлал ёсоор зохион байгууллаа.



ISO БАТАЛГААЖУУЛАЛТ

Женевт төвтэй ISO стандартын олон улсын гэрчилгээжилтийн SGS (General Society of Surveillance) компаниар ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцоо стандартын аудит хийлгэн сертификатаа амжилттай гардаж авлаа.



Зорилго:

“Эх дэлхий дээрх ул мөрөө багасгахын тулд тогтсон хязгаарыг давсан зүтгэл гаргаж, өвөг дээдсийнхээ хадгалан үлдээсэн тэнцвэртэй байгаль орчныг идэвхтэй хамгаална.”

Усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус"-ны Ерөнхий шаардлага - MNS 6561:2015" стандартад заагдсан 9 үзүүлэлт тодорхойлдог ба “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 17025” стандартаар анх удаа итгэмжлэгдлээ.



ҮЕРИЙН ҮЕИЙН ХАНДИВ, ТУСЛАМЖ

Их баяр Наадмын үеэр 7-р сард их хэмжээгээр орсон борооны улмаас үер усны гамшиг нүүрлэхэд Онцгой комисс, Цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүн болон гамшгийн бүсэд нэгдэн ажиллаж буй аж ахуй нэгжүүдэд зориулан “Шунхлай Групп”-ийн харьяа компаниуд нэгдэж нийт 200 сая төгрөгийн шатахуун, халуун хоол, цэвэр ус, дархлаа дэмжих сүүн бүтээгдэхүүн, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл, ариутгалын спирт зэрэг бусад эд материалын дэмжлэг үзүүлэн ажиллав. Мөн нийт аж ахуй нэгж, иргэд олон нийтэд сонор сэрэмж өндөр байж, гамшгийн нөхцөл байдлын эсрэг шуурхай арга хэмжээ аван, бүхий л хүчин чармайлтаа нэгтгэн ажиллахыг уриалан ажиллалаа.



АПУ ХК-ийн охин компани СББ ХХК Сэлэнгэ аймгийн Мандал суманд буусан үерийн нөхцөл байдлыг даван туулахад зориулан мөнгөн тусламж, бүтээгдэхүүн, ажиллах хүн хүчээр Мандал сумын онцгой комисст дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллалаа.

“ХАТАН ТУУЛ ГОЛОО ХАМТДАА ЦЭВЭРЛЭЭ” ҮЙЛ АЖИЛЛАГАА

М Би Си Азиа Пасифик ХХК-ийн хамт олон “Хатан Туул голоо хамтдаа цэвэрлэе” үйл ажиллагааг өөрсдийн санаачлагаар зохион байгуулж, Гачууртын эцсээс Монгол шилтгээн хүртэлх нийт 2.5 км Туул голын эргийн ай сав газрыг цэвэрлэлээ.

Тус үйл ажиллагааг хог хаягдлыг багасгахад олон нийтийг уриалах, ажилтнуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилготойгоор жил бүр зохион байгуулдаг бөгөөд нийт 42 ажилтан оролцож, 30 шуудай хог хаягдлыг цуглуулан Баянзүрх дүүргийн хот тохижилтын компанид хүлээлгэн өгсөн юм.



ИРЭЭДҮЙН ЭЗДИЙН ШИЙДЭЛ: ХОГ ХАЯГДЛЫН ЗАСАГЛАЛ

Хүн бүрт хөгжил дэвшлийг хүртээмжтэй байлгах, ядуурлыг бууруулах, эх дэлхийгээ хамгаалахыг зорьж буй Тогтвортой хөгжлийн 17 зорилтыг хэрэгжүүлэх хүчин чармайлтаа АПУ ХК нэмэгдүүлэн ажиллаж байна. Эх дэлхийгээ хайрлах, аливаа сөрөг нөлөөллүүдийг хязгаарлах, нийгэм, эдийн засагт эергээр нөлөөлөх тогтвортой хөгжлийн арга хэмжээг сурталчлан таниулах, татан оролцуулж, хамтран хэрэгжүүлэхэд залуусын оролцоо ихээхэн чухал юм. Энэ хүрээнд залуусын дунд зохион явуулсан “Гэрэгэ” клубийн

парламентын мэтгэлцээнийг дэмжин ажиллалаа. Залуусын нийгмийн тогтвортой хөгжлийн асуудлуудад шийдэл олоход төвлөрсөн энэхүү мэтгэлцээнд Улаанбаатар хотын хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашиглах тогтолцоог төр болон хувийн хэвшил хамтран хөгжүүлэх, эдийн засгийн төвлөрлийг орон нутаг руу чиглүүлэх гэх мэт чухал сэдвүүдээр мэтгэлцсэн юм. Цаашид бид тогтвортой хөгжлийг дэмжин ажиллах аливаа үйл ажиллагаандаа залуусын оролцоог дэмжин ажиллаж, тэдний тогтвортой

хөгжлийн сэдвийн хүрээнд хийсэн мэтгэлцээний үр дүнд гарсан шийдлийг төсөл хөтөлбөртөө шингээн хэрэгжүүлэхийг чармайн ажиллаж байна. Залуусын дунд шийдэлд чиглэсэн хэлэлцүүлгийг дэмжих, дуу хоолойг өргөхөд бид цаашдаа ч идэвхтэй оролцсоор байх юм.



“MODEL UN” ЖИШИГ БАГА ХУРАЛ

Монгол төдийгүй дэлхийн иргэд болох ЕБС-ийн сурагчид НҮБ-ын Загвар хуралдаанаар дамжуулан жил бүр дэлхий нийтэд тулгамдаж буй асуудлуудыг хөндөн, бусад оролцогчидтойгоо хамтарч, мэтгэлцээний үр дүнд шийдэл гаргадаг. Үе тэнгийн манлайлагч залуустайгаа хамтран сэтгэн бодож, асуудалд дүгнэлт хийж, багаар ажиллах ур чадварыг суулгахад зорьдог энэхүү арга хэмжээг АПУ ХК дэмжин ажилласандаа тун их баяртай байна.



ХӨВСГӨЛ НУУРЫГ ЦЭВЭРЛЭХ АВТОМАШИН

Хөвсгөл нуур орчимд цуглардаг эзэнгүй хог хаягдлыг 20 жилийн турш цэвэрлэж, ангилан ялгаж яваа “Хогийн Сайнаа” гэгддэг ‘Хүн байгаль бүлэг’-ийн ахлагч Ж. Сайнбаяртай хамтран ажиллалаа. Тэрбээр “Овоонд өргөдөг мөнгөө Хөвсгөл нуурыг цэвэрлэх автомашин авахад зарцуулъя” хэмээн уриалж, хандивын аян эхлүүлсэн. Тэгвэл автомашин авахад шаардлагатай байсан 25 сая төгрөгийн 13 сая төгрөгийг “АПУ” ХК хандивлав. Ийнхүү иргэд, аж ахуй нэгжийн өгсөн хандиваар “Хогийн Сайнаа” “ЗИЛ-130” автомашинтай боллоо.



ХҮҮХЭД ЗАЛУУСЫН НОГООН ДЭЛХИЙН ЗУРАГЛАЛ



Байгальд ээлтэй хэрэглээг дэмжих, эерэг хандлага түгээх, ногоон дадлыг дэмжих зорилгоор “Байгальд биш байх ёстой газар нь” хүүхдийн гар зургийн уралдаан болон Reel & Tik Tok уралдааныг залуусын дунд зарлан зохион байгуулав. Хүүхэд, залуучуудыг эдгээр уралдаануудад

оролцуулснаар бид ирээдүйн байгаль орчин, эх дэлхийдээ үзүүлж буй нөлөөллөө ухамсарладаг оршин суугчдыг бэлдэх, өөрсдийн бий болгохыг хүсдэг төсөөллөө дүрслэн харуулахдаа тогтвортой байдлын ач холбогдлын талаар улам гүнзгий ойлгох сэдэл болсон хэмээн найдаж

байна. Уралдаанд оролцогчид бүтээлч аргуудыг ашигласнаар бусдад эх дэлхийгээ хамгаалж, хайрлахын ач тусыг өөрсдөдөө ойр, хүлээж авахад сонирхолтой байдлаар хүргэсэн билээ. Бяцхан зураачдын маань бүтээлийн дээжээс та бүхэн дээр харуулснаас сонирхоорой.

“НАРНЫ ХҮҮХДҮҮД-3” НОГООН ЦЭЦЭРЛЭГ

АПУ ХК “Нарны хүүхдүүд-3” эко ногоон шинэ цэцэрлэгийн барилгын хөрөнгө бүрдүүлэх арга хэмжээг дэмжин хамтран ажиллалаа. Энэхүү арга хэмжээ нь Вэлүү сангаас “Gobi Gallop Gala” нэртэйгээр зохион байгуулагддаг бөгөөд 10 дахь жилдээ 2023 онд болж өнгөрсөн.

“Вэлүү сан” нь Нарны хүүхдүүд 1,2-р цэцэрлэгийг амжилттай бүтээн байгуулж 2013 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж өдгөө 300 гаруй хүүхдэд сургуулийн өмнөх боловсролыг олгож байна.

Энэхүү шинэ цэцэрлэг баригдсанаар тус сангийн цэцэрлэгийн хүчин чадал 3 дахин нэмэгдэх бөгөөд сургуулийн өмнөх боловсролын хүртээмж сайжрах юм. Нийгэмд чиглэсэн ажлуудыг удаан хугацаанд, олон талын оролцоог амжилттай ханган хэрэгжүүлсээр байгаа Вэлүү сангийн нийт хамт олонд баяр хүргэн талархал илэрхийлье.



ХҮЧИРХЭГЖСЭН ХАМТ ОЛОН

СУРГАЛТ ХӨГЖИЛ

АПУ компани нь ажилчдынхаа сурч хөгжих, гадаад улсад мэргэжил дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулахаас гадна туршлага солилцох зорилгоор ажилтан солилцоогоор ажиллах боломжийг хангаж өгдөг.



Тухайлбал Үйлдвэрлэл, үйл ажиллагааны газрын хүрээнд Инженер болон техникийн ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зорилгоор 2023 оны 04 сард Савлалтын үйлдвэр болон Тайгер үйлдвэрийн автоматик болон механикийн техникч, инженер болох 8 ажилтныг Хятад улсын Тайсан хот дах Кронесийн сургалт, лабораторийн төвд 7 өдрийн сургалт, семинарт хамрууллаа. Энэхүү сургалтаар ажилтнууд мэргэжлийн шинэ технологи, чиг хандлагатай танилцаж, лаборатори дадлагыг хийж, олон улсын үйлдвэрлэлийн чиг хандлага, дагаж мөрдөж буй стандарт зэрэгтэй танилцсан юм.



Зорилго:

“Хамт олон, бусад гол оролцогч талууд маань хөгжиж дэвших боломж бүхий монгол гэр бүлийн үнэт зүйлд нийцүүлсэн ажлын орчныг хөгжүүлснээрээ манлайлагч ажил олгогч болно.”

“HEINEKEN” – ТУРШЛАГА

Бид дэлхийн топ үйлдвэрлэгч HEINEKEN компанийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, туршлага, чанар стандартыг бүхий л түвшиндээ нэвтрүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд дэлхийн зах зээлд томоохон тоглогч болж буй HEINEKEN компанид ажилчин солилцоогоор ажиллах боломжийг компанийн зүгээс нээлттэй олгодог.



Тухайлбал АПУ ХК-ийн төлөвлөлтийн ажилтан Э.Намуунцэцэг Малайз улсын нийслэл Куала Лумпурт байрлалтай Хайнекен компанид Борлуулалт, үйл ажиллагаа төлөвлөлтийн чиглэлээр туршлага солилцон 6 сарын хугацаанд ажиллаж, өөрийн туршлага мэдлэгээ сайжруулан, олон улсын чанар стандарт, борлуулалт үйлдвэрлэлийн төлөвлөлттэй холбоотой төслүүд дээр амжилттай ажиллалаа.

Олон улсын түвшний чадварлаг хүний нөөц
АПУ ХК нь дэлхийн топ үйлдвэрлэгч HEINEKEN компанийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, туршлага, чанар стандартыг бүхий л түвшиндээ нэвтрүүлэн ажиллаж байна.



Олон улсын зах зээлд Монгол үндэсний брэнд бүтээгдэхүүнийг борлуулах нь бидний үндсэн зорилго. Иймд бид дэлхийн топ үйлдвэрлэгч HEINEKEN компанийн чанар стандарт, ноу-хауг бүхий л шатандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Б.ТАМИР
АПУ ХК-ийн Брэнд менежер

БАЯЛАГ, ХАРИУЦЛАГАТАЙ

Зорилго:

“Өдөр тутмын амьдрал болон хэрэглээнд эрүүл сонголтуудыг сэдэлжүүлж, боломжийг нэмснээр Монгол мөн чанар шингэсэн зохистой амьдралын хэв маягийг дэвжээнэ.”

ХҮРТЭЭМЖТЭЙ, ХАРИУЦЛАГАТАЙ МЭДЭЭЛЛИЙГ ДИЖИТАЛ ШОШГООР



Бид бүтээгдэхүүндээ инновацыг тасралтгүй нэвтрүүлж, шинэлэг шийдлүүдийг шингээн ажиллахыг эрмэлздэг. Дэлхий даяар зохистой хэрэглээг хэрэглэгчдэдээ сурталчлан таниулж, мэдлэгжүүлэх олон төрлийн аян өрнөж буй энэ үетэй АПУ ХК хөл нийлүүлэн алхаж бүтээгдэхүүнүүддээ зохистой, хариуцлагатай хэрэглээг таниулах, дижитал, хүртээмжтэй шийдлийг нэвтрүүлж буй нь энэ юм.

ХАРИЛЦАГЧДЫН МЭДЛЭГ: COMFORT CONNECT

“COMFORT CONNECT” харилцагчийн арга хэмжээг зохион байгуулж, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ шинэчилсэн хуулийн танилцуулгын мэдээллийг хүргэж, харилцагч байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах шинэ бүтээгдэхүүнийг танилцуулах уулзалтыг зохион байгуулав. Мөн 250 гаруй харилцагчийг Архи, Шар айраг, Ус ундааны үйлдвэрүүдтэй танилцуулж хамтын ажиллагаагаа өргөжүүлэн үйлдвэрлэлийн үйл явцаа танилцуулсан юм. Энэхүү үйлдвэрийн аяллын гол ач холбогдол нь харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, хамтын тогтвортой харилцааг бий болгох, дотооддоо бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй давуу талуудыг харилцагч нарт ойлгуулах явдал байв.



“ГАЙХАМШИГТ ЖОЛООЧ - УУСАН БОЛ ЖОЛОО БАРЬДАГГҮЙ” НӨЛӨӨЛЛИЙН АЯН



АПУ ХК “Соёлоор гоёно” хөтөлбөрийн дэд хэсэг болох “Гайхамшигт жолооч - Уусан бол жолоо барьдаггүй” нөлөөллийн аянг 2023 онд хэрэгжүүлж, 10,000 хүний амлалтыг аваад байна. Компанийн тогтвортой хөгжлийн бодлогын нэг хэсэг болох “Хариуцлагатай хэрэглээ”-г сэдэлжүүлэх гол зорилгоор замын хөдөлгөөний аюулгүй байдал, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохын эсрэг хэрэгжүүлж буй ажил бөгөөд бид Тээврийн Цагдаагийн алба, “UB Cab” байгууллагуудтай хамтран ажиллаж, жолоодлогын үйлчилгээний талаарх мэдлэг, мэдээллийн хүртээмжийг

нэмэгдүүлсэн нь энэ юм. Энэ хүрээнд “UB Cab”-аас зохион байгуулсан 1000 жолоочийн чуулга уулзалтад энэхүү нийгмийн эерэг нөлөөллийн аянаа танилцуулан оролцож, жолооч нарын амлалтыг авах байдлаар зан төлөвт нь нөлөөлөх, амлалт өгсөн бол хэрэгжүүлэх сэдэл идэвхтэй төрдөг талаарх судалгаан дээр үндэслэн олон нийтэд уриалан ажиллаж байна. Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “ОктоберФест” болон “Их Хотын Баяр” арга хэмжээнүүдээр дамжуулан АПУ ХК тус аяныг танилцуулж, хүрэлцэн ирсэн нийт 6,400 залууст хүрч, мэдээллийг түгээжээ..



СПОРТЫГ ДЭМЖИХ ХАМТЫН АЖИЛЛАГАА

FC ULAANBAATAR

АПУ ХК нь хөлбөмбөгийн спортын хөгжлийг дэмжих замаар залуучуудын эрүүл амьдралын хэв маяг, зөв дадал хэвшлийг бий болгох зорилгоор “ФС УЛААНБААТАР” хөлбөмбөгийн шигшээ багийг сүүлийн 10 орчим жилийн хугацаанд дэмжин, хамтран ажиллаж байна. 2023 оны хөлбөмбөгийн дээд лигийн аварга болсноор улсаа төлөөлөн олон улсын тэмцээн болох Азийн Клубуудын аварга шалгаруулах тэмцээнд 6 тоглолтоос 4-т нь хожиж, Монголын хөлбөмбөгийн түүхэн дэх дээд амжилтыг тогтоосон билээ.



ҮНДЭСНИЙ ДЭЭД ЛИГ

АПУ ХК нь залуучуудын эрүүл амьдралын хэв маягийг дэмжих, зөв зохистой, хариуцлагатай хэрэглээг сурталчлах зорилгоор сагсан бөмбөгийн спортын хөгжилд хувь нэмэр оруулан “Монголын Сагсан Бөмбөгийн Холбоо” /МСБХ/-той 2 дахь жилдээ хамтран Үндэсний Дээд Лиг 2023-2024 оны улирлыг амжилттай зохион байгууллаа. Мөн АПУ ХК-ийн Сэнгүр брэнд нь 2013 оноос Үндэсний Сагсан Бөмбөгийн Холбооноос зохион байгуулдаг Монголын хамгийн том, чансаа өндөртэй Супер Лиг болон Үндэсний 21 аймгийн лигийн ерөнхий ивээн тэтгэгчээр тасралтгүй 10 жил ажиллаж, спортод хайртай залуусын сонирхол, хүсэл тэмүүллийг ийнхүү дэмжсээр байна.



15 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

- Дэлгэрэнгүй орлогын тайлан
- Санхүү байдлын тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Тайлагналын зарчим
- Тайлбар толь



ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

		Аудитлагдсан НСТ 2023	Аудитлагдсан НСТ 2022
Борлуулалтын орлого (цэвэр)	сая.төг	1,105,352	850,240
Борлуулалтын өртөг	сая.төг	(625,950)	(478,213)
Нийт ашиг (алдагдал)	сая.төг	479,402	372,027
Борлуулалт, удирдлагын зардал	сая.төг	(299,608)	(201,932)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	сая.төг	(81)	112
Бусад орлого	сая.төг	6,355	7,656
Бусад зардал	сая.төг	(10,722)	(13,410)
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	175,345	164,452
Санхүүгийн орлого	сая.төг	1,938	151
Санхүүгийн зардал	сая.төг	(19,619)	(10,491)
Татварын өмнөх ашиг	сая.төг	157,663	154,112
Орлогын албан татварын зардал	сая.төг	(40,605)	(28,215)
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	117,058	125,898
Бусад дэлгэрэнгүй орлого			
Ашиг, алдагдал руу дахин ангилагдахгүй зүйлс:			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	сая.төг	2,334	65,810
Ажилчдын тэтгэмжийн дахин хэмжилтийн алдагдал	сая.төг	+280	(439)
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	сая.төг	(760)	747
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	сая.төг	118,912	192,015
Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ноогдох	сая.төг	146,795	144,693
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох	сая.төг	(29,736)	(18,795)
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	117,058	125,898
Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ноогдох	сая.төг	146,795	210,811
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох	сая.төг	(29,736)	(18,795)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлогын нийт дүн	сая.төг	118,912	192,015
Нэгж хувьцаанд ноогдох ашиг			
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг /алдагдал/	сая.төг	137.9	136.1

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

		Аудитлагдсан НСТ 2023	Аудитлагдсан НСТ 2022
Хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	сая.төг	498,808	415,600
Биет бус хөрөнгө ба гүүдвил	сая.төг	69,117	74,045
Хойшлогдсон татварын хөрөнгө	сая.төг	981	1,337
Биологийн хөрөнгө	сая.төг	624	
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	569,529	490,982
Бараа материал	сая.төг	221,238	185,883
Урьдчилгаа, урьдчилж төлсөн зардал	сая.төг	27,781	65,530
Орлогын албан татварын авлага	сая.төг	7,833	9,656
Дансны болон бусад авлага	сая.төг	69,307	51,008
Бусад санхүүгийн хөрөнгө оруулалт	сая.төг	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	сая.төг	122,152	38,365
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	сая.төг	642	709
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	448,952	351,152
Нийт хөрөнгө	сая.төг	1,018,481	842,134
Эздийн өмч			
Хувьцаат капитал	сая.төг	106	106
Нэмж төлөгдсөн капитал	сая.төг	339,443	338,095
Нэгдлийн нөөц	сая.төг	(112,796)	(112,796)
Дахин үнэлгээний нөөц	сая.төг	157,839	156,567
Гадаад валютын хөрвүүлгийн нөөц	сая.төг	(57)	704
Хуримтлагдсан ашиг	сая.төг	274,270	220,738
Хяналтын эрхгүй хувь оролцоо	сая.төг	21,770	30,163
Нийт эздийн өмч	сая.төг	680,576	633,577
Өр төлбөр			
Хойшлогдсон татварын өглөг	сая.төг	29,888	25,540
Урт хугацаат бусад өглөг	сая.төг	-	2,326
Урт хугацаат түрээсийн өглөг	сая.төг	41,528	31,334
Ажилтны тэтгэмж	сая.төг	990	1,381
Урт хугацааны зээл	сая.төг	107,392	18,333
Бусад урт хугацаат өр төлбөр		432	
Урт хугацаат өр төлбөр	сая.төг	180,231	78,913
Богино хугацаат түрээсийн өглөг	сая.төг	18,593	10,935
Орлогын албан татварын өглөг	сая.төг	1,563	191
Дансны өглөг	сая.төг	53,135	51,633
Бусад өглөг	сая.төг	44,384	61,718
Богино хугацаат зээл	сая.төг	40,000	5,167
Богино хугацаат өр төлбөр	сая.төг	157,674	129,644
Нийт өр төлбөр	сая.төг	337,906	208,557
Нийт өр төлбөр ба эздийн өмч	сая.төг	1,018,481	842,134

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

		Аудитлагдсан НСТ 2023	Аудитлагдсан НСТ 2022
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн ашиг	сая.төг	117,058	125,898
Тохируулга:	сая.төг	-	-
Орлогын албан татварын зардал	сая.төг	40,605	28,215
Зээлийн хүүгийн зардал	сая.төг	10,329	1,917
Түрээсийн хүүгийн зардал	сая.төг	7,647	4,729
Дераватив санхүүгийн өр төлбөрийн хүүгийн зардал		964	
Нөөцийн дискаунтын чөлөөлөлт	сая.төг	215	56
Хүүгийн орлого	сая.төг	(1,545)	(151)
Валютын ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй гарз/(олз), цэвэр	сая.төг	55	6,222
Элэгдлийн зардал	сая.төг	75,198	59,294
Хорогдуулгын зардал	сая.төг	7,666	7,466
Дансны болон бусад авлагын үнэ цэнийн бууралт, (цэвэр)	сая.төг	(180)	48
Банкны үлдэгдэл дэх үнэ цэнийн бууралт	сая.төг	261	(160)
Урьдчилж төлсөн төлбөрийн үнэ цэнийн бууралт	сая.төг	-	-
Бараа материалын үнэ цэнийн бууралт	сая.төг	(74)	22
Данснаас хассан бараа материал	сая.төг	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	сая.төг	(117)	(128)
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	сая.төг	295	29
Хасагдсан үндсэн хөрөнгө	сая.төг	714	589
Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	сая.төг	2,336	8,358
Дераватив санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн алдагдал		432	
Биологийн хөрөнгө борлуулсаны гарз		269	
Биет бус хөрөнгө борлуулсны гарз	сая.төг	-	-
Өмчөөр барагдуулах төлбөрийн ажил гүйлгээ		1,348	
	сая.төг	263,477	242,404
Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт:			
Дансны авлага болон бусад авлага	сая.төг	(19,067)	(17,467)
Бараа материал	сая.төг	(34,582)	(97,862)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	сая.төг	67	(709)
Урьдчилгаа	сая.төг	24,684	(13,210)

		Аудитлагдсан НСТ 2023	Аудитлагдсан НСТ 2022
Дансны өглөг	сая.төг	2,935	25,560
Бусад өглөг	сая.төг	(3,280)	25,273
Ажилтны тэтгэмж	сая.төг	(326)	69
	сая.төг	233,907	164,059
Зээлийн хүүний төлбөрт төлсөн	сая.төг	(10,329)	(579)
Түрээсийн хүүний төлбөрт төлсөн	сая.төг	(7,647)	(4,729)
Дераватив санхүүгийн өр төлбөрийн хүүний төлбөр төлсөн		(368)	
Хүлээн авсан хүүгийн орлого	сая.төг	1,545	151
Төлсөн орлогын албан татвар	сая.төг	(32,725)	(46,257)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	184,383	112,646
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Худалдаж авсан үндсэн хөрөнгө	сая.төг	(117,750)	(92,642)
Худалдаж авсан биет бус хөрөнгө	сая.төг	(2,738)	(547)
Худалдаж авсан хяналтын эрхгүй хувь оролцоо	сая.төг	-	-
Борлуулсан үндсэн хөрөнгө	сая.төг	3,911	413
Бусад санхүүгийн хөрөнгө оруулалтыг олж эзэмшихэд төлсөн	сая.төг	(892)	-
Бусад санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсан	сая.төг	-	-
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(117,469)	(92,777)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Зээлийн эргэн төлөлт	сая.төг	(105,900)	(45,500)
Төлсөн ногдол ашиг	сая.төг	(111,481)	(100,763)
Түрээсийн өглөгт төлсөн	сая.төг	(15,680)	(6,474)
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	сая.төг	21,343	25,098
Урт хугацааны зээл авсан	сая.төг	230,570	67,000
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	18,853	(60,639)
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	сая.төг	(921)	309
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт / (бууралт)	сая.төг	84,845	(40,461)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	сая.төг	38,365	77,278
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийн бууралт	сая.төг	(261.38)	160
Мөнгөн хөрөнгө дэхь гадаад валютын ханшийн хэлбэлзлийн нөлөөлөл	сая.төг	(796.85)	1,388
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	сая.төг	122,152	38,365

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Нэгдлийн нөөц	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн	Хяналтын эрхгүй хувь оролцоо	Нийт дүн	
2022 эхний үлдэгдэл / нэгтгэсэн/	сая. төг	106	338,095	(112,796)	92,842	(43)	186,012	504,216	84	504,300
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	сая. төг	-	-	-	-	-	-	-	-	-
2022 эхний үлдэгдэл / нэгтгэсэн/	сая. төг	106	338,095	(112,796)	92,842	(43)	186,012	504,216	84	504,300
Нийт дэлгэрэнгүй орлого	сая. төг	-	-	-	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	сая. төг	-	-	-	-	-	144,693	144,693	(18,795)	125,898
Бусад дэлгэрэнгүй орлого	сая. төг	-	-	-	65,810	747	(439)	66,118	-	66,118
Зарласан ногдол ашиг	сая. төг	-	-	-	-	-	(111,612)	(111,612)	-	(111,612)
Худалдаж авсан хяналтын эрхгүй хувьцаа	сая. төг	-	-	-	-	-	-	-	-	-
Нэмэгдүүлсэн хувьцаат капитал	-	-	-	-	-	-	-	48,874	-	48,874
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн	сая. төг	-	-	-	(2,085)	-	2,085	-	-	-
2022 эцсийн үлдэгдэл / нэгтгэсэн/	сая. төг	106	338,095	(112,796)	156,567	704	220,739	603,414	30,163	633,577
Нийт дэлгэрэнгүй орлого	сая. төг	-	-	-	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	сая. төг	-	-	-	-	-	146,795	146,795	(29,736)	117,058
Бусад дэлгэрэнгүй орлого	сая. төг	-	-	-	2,334	(760)	280	1,854	-	1,854
Зарласан ногдол ашиг	сая. төг	-	-	-	-	-	(94,605)	(94,605)	-	(94,605)
Худалдаж авсан хяналтын эрхгүй хувьцаа	сая. төг	-	-	-	-	-	-	-	-	-
Нэмэгдүүлсэн хувьцаат капитал	сая. төг	0	1,348	-	-	-	-	1,348	21,343	22,691
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн	сая. төг	-	-	-	(1,062)	-	1,062	-	-	-
2023 эцсийн үлдэгдэл / нэгтгэсэн/	сая. төг	106	339,443	(112,796)	157,839	(57)	274,270	658,805	21,770	680,575

ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

ТАЙЛАГНАЛЫН НИЙЦЭЛ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Монгол улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актын хүрээнд бэлтгэсэн. Угтайланг Санхүүгийн тайлангийн Олон Улсын Стандарт (“СТОУС”) 10 буюу “Нэгтгэсэн санхүүгийн Тайлан” хэмээх стандартын арга аргачлалыг ашиглан бэлтгэсэн.

ҮНЭЛГЭЭНИЙ СУУРЬ

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулахдаа санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн.

БҮРТГЭЛИЙН БОЛОН ТОЛИЛУУЛГЫН ВАЛЮТ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг компанийн бүртгэлийн валют болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр толилуулсан бөгөөд энэ нь компанийн үйл ажиллагаа явуулж буй анхдагч эдийн засгийн орчны үндсэн валют болно.

ТААМАГЛАЛ, ТООЦООЛОЛ БОЛОН ҮНЭЛЭМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС болон НББОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, мөн хөрөнгө, өр төлбөр, орлого зардлын зүйлсийн дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно. Удирдлага эдгээр тооцоолол болон түүнд хэрэглэсэн таамаглалыг байнга хянаж байдаг.

ГАДААД ВАЛЮТААРХ АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн зүйлсийг балансын өдрийн хаалтын ханшаар төгрөг рүү хөрвүүлэн илэрхийлдэг.

Бодит үнэ цэнээр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийн зүйлсийг тухайн бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлдэг. Түүхэн өртгөөр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар тайлагнадаг.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ. Компани нь зээл болон авлагыг анх үүссэн тухай бүр нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн хөрөнгүүдийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг. АВЛАГА. Уг хөрөнгийг бодит үнэ цэнэ дээр тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан шууд зардлыг нэмсэн дүнгээр анх хүлээн зөвшөөрдөг.

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР. Компани нь гаргасан өрийн бичиг, өр төлбөрийг тухайн ажил гүйлгээг үүссэн өдрөөр хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн

өр төлбөрийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг.

САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨРИЙГ ЦЭВЭР ДҮНГЭЭР ТУСГАХ.

Компани хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хаах хууль эрх зүйн эрхтэй байх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

ҮНДСЭН ХӨРӨНГӨ АНХДАГЧ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ.

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлсийг анхны удаа өртгөөр нь хэмждэг. Өртөгт тухайн хөрөнгийг худалдан авахтай шууд холбогдон гарсан зардлууд багтдаг.

ДАРАА ҮЕИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ.

Барилга байгууламж, газар, тоног төхөөрөмжийн бүлэг үндсэн хөрөнгийг хөрөнгөөр хүлээн зөвшөөрсний дараа түүний бодит үнэ цэнийг илтгэх дахин үнэлсэн дүнгээр хэмжих ба дахин үнэлсэн дүн нь дараа үеийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байдаг. Хөрөнгийн бодит үнэ цэнийг Монгол Улсын хараат бус гуравдагч этгээд тогтоодог.

ДАРАА ҮЕИЙН ЗАРДАЛ. Дараа үеийн зардлыг зөвхөн эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай гэдэг нь тогтоогдсон үед капиталжуулан бүртгэдэг. Урсгал засварын зардлыг гарсан тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрдөг.

ЭЛЭГДЭЛ.

Үндсэн хөрөнгийн зүйлсийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн ашиглалтын жилээр тооцон шулуун шугамын аргаар элэгдүүлж, орлогын тайланд бүртгэдэг. Үндсэн хөрөнгийг түүнийг байршуулж, ашиглахад бэлэн болсон үеэс нь, дотооддоо барьж байгуулсан хөрөнгийн хувьд тэдгээрийг дуусгавар болгож, үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон үеэс нь эхлэн элэгдэл байгуулдаг.

БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Компани биет бус хөрөнгө худалдан авсан бөгөөд түүний ашиглалтын жилийг тодорхойлох боломжтой бол түүний өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ

Биологийн хөрөнгийг борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр нь хэмжих бөгөөд үүнтэй холбоотой үүсэх олз ба гарзыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

ЗЭЭЛИЙН ӨРТӨГ

Компани бэлтгэл шаардагдах хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртгийн хэсэг болгон капиталжуулдаг. Бусад зээлийн өртгийг гарсан

тайлант үед нь зардлаар хүлээн зөвшөөрдөг.

БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар үнэлдэг. Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргаар тодорхойлох бөгөөд бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан бүх зардлууд ордог. Үйлдвэрийн бараа материал, дуусаагүй үйлдвэрлэлийн хувьд хэвийн хүчин чадлаар ажиллах үеийн үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын зохих хэсгийг өртөгт хуваарилдаг.

ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдээгүй санхүүгийн хөрөнгийн хувьд тэдгээрт үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг бодит нотолгоо байгаа эсэхийг тайлант хугацааны эцэс бүрт үнэлж тодорхойлдог.

ХОРОГДУУЛСАН ӨРТГӨӨР ИЛЭРХИЙЛСЭН САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.

Компани эдгээр хөрөнгүүдийг тусад нь мөн хамтад нь үнэ цэнийн бууралтын нотолгоо байгаа эсэхийг үздэг. Бүх мэдэгдэхүйц хэмжээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тусад нь үнэлнэ.

САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ.

Тайлант үеийн эцэст бараа материал, хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад санхүүгийн бус хөрөнгийн дансны үнэнд үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно.

АЖИЛЧДЫН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, УРАМШУУЛАЛ АЖИЛЧДЫН БОГИНО ХУГАЦААТ ТЭТГЭМЖ. Холбогдох үйлчилгээ үзүүлсэн үед ажилчдын богино хугацаат тэтгэмжийг зардлаар бүртгэдэг. Компани нь ажилтны үзүүлсэн үйлчилгээний дагуу компанид үүрэг хариуцлага үүссэнээс найдвартайгаар тооцоолж болох компанийн төлөх ёстой дүнгээр өр төлбөрөө хүлээн зөвшөөрдөг.

ТОГТООСОН ШИМТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.

Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж нь Монгол Улсын Нийгмийн Даатгалын Санд төвлөрүүлэх хуулиар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлээс бүрдэнэ. Тодорхой шимтгэлийн дүн бүхий тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөрт төвлөрүүлэх шимтгэлийг түүнийг төлөх үүрэг хүлээсэн тайлант үеийн зардлаар бүртгэдэг.

НӨӨЦ БА БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Компани өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөц шаардлагатай гэдэг нь тодорхой болсон ба үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой болсон үед санхүүгийн байдлын тайланд нөөцийг хүлээн зөвшөөрдөг.

ХУВЬЦААТ КАПИТАЛ ЭНГИЙН ХУВЬЦАА.

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж, бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.

ХАЛААСНЫ ХУВЬЦАА.

Хувьцаат капиталыг буцаан худалдан авсан үед аливаа татварын нөлөөллийн дараах худалдан авахтай холбоотой гарсан шууд зардлыг багтаасан дүнгээр эздийн өмчийн бууралт гэж бүртгэдэг.

Буцаан худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж нэрлэх бөгөөд өмчийн өөрчлөлтийн тайланд халаасны хувьцаа гэж тайлагнадаг. Халаасны хувьцааг дахин борлуулсан эсвэл дахин эргэлтэнд гаргасан үед хүлээн авсан дүнг өмчийн өсөлтөөр бүртгэдэг бөгөөд тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан өсөлт, бууралтыг нэмж төлөгдсөн капитал гэж толилуулдаг.

ХУВЬЦААТ КАПИТАЛ, НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ БА БУСАД НӨӨЦҮҮД

Эвэргрийн Инвестментс ХХК-тай нэгдсэн талаар Холбогдох эрх бүхий байгууллагуудаас зохих зөвшөөрлүүдийг шат дараатай авсны үндсэн дээр нэгдлийн ажил гүйлгээ 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөр дуусгавар болсон. Эцсийн үе шатанд Эвэргрийн Инвестментс ХХК компанид нэгдсэн бөгөөд компани нь нэгдсэн компаниуд, тэдгээрийн охин компаниудын толгой компани болсон. Нэгдлийн үр дүнд дараах өмчийн дахин зохион байгуулалтыг хийсэн:

2017 оны 8 дугаар сарын 18-ны өдөр компанийн хувьцаа эзэмшигчид нийт 338,127,000 мянган төгрөгөөр капиталыг нэмэгдүүлэх замаар Эвэргрийн Инвестментс ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд нийт 321,305 мянган ширхэг энгийн хувьцааг шинээр гаргасан. Уг капитал нь 32,130 мянган төгрөгийн хувьцаат капитал болон 338,094,870 мянган төгрөгийн нэмж төлөгдсөн капиталаас бүрдсэн.

Нэгдлийн нөөц

Бизнесийн нэгдлийн хүрээнд компанийн шилжүүлсэн төлбөр нь Эвэргрийн Инвестментс ХХК-тай хийсэн нэгдэлд зориулж шинээр гаргасан хувьцаа болно. Өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо бодит үнэ цэнийн 1 дүгээр шатлалын хэмжүүр болох компанийн хувьцааны зах зээлийн үнэ цэнийг ашигласан. Нэмж гаргасан хувьцааны бодит үнэ цэнэ болон хуулийн дагуу бүртгэгдсэн үнэ цэнийн зөрүү болох 112,795,804 мянган төгрөгийг нэгдлийн нөөц гэж бүртгэсэн.

ОРЛОГО

Бараа борлуулалтын орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжиж бүртгэлд тусгадаг. Ингэхдээ компани эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлал өндөр бөгөөд орлого ба өртөг зардлыг бодитоор хэмжих боломжтой байх ёстой.

БАРАА БОРЛУУЛАЛТ.

Бараа агуулахаас ачигдан, худалдан авагчийн талбайд хүргэгдэж, худалдан авагч барааг хүлээн авч, эрсдэл болон өмчлөл нь худалдан авагчид бүрэн шилжсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрдөг.

Орлогын дүнд нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад борлуулалтын татварыг оруулдаггүй ба худалдааны хөнгөлөлт, урамшууллыг хассан цэвэр дүн байдаг.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮРЭЭСИЙН ОРЛОГО. Үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн хугацааны туршид төлөгдөх ижил хэмжээний хэсэгчилсэн төлөлтөөр орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Хүлээн авсан түрээсийн хөрөнгийн урамшууллыг түрээсийн нийт зардлын дүнд тооцон түрээсийн хугацааны туршид хүлээн зөвшөөрдөг. Болзошгүй түрээсийн орлогыг тухайн орлогыг олсон тайлант хугацаанд хүлээн зөвшөөрдөг.

БУСАД ОРЛОГО.

Компанийн үндсэн үйл ажиллагаанаас гадна бий болж буй орлогыг бусад орлого гэх бөгөөд тухайн орлогын эдийн засгийн өгөөжийг компани хүртэх магадлалтай ба үүнийг найдвартай хэмжин тодорхойлох боломжтой болсон үед компани бусад орлогыг хүлээн зөвшөөрдөг.

САНХҮҮГИЙН ОРЛОГО БА САНХҮҮГИЙН ЗАРДАЛ

Санхүүгийн орлогод хөрөнгө оруулалтаас хүртэх хүүгийн орлого орно. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд хуримтлуулан бүртгэдэг.

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрддэг. Зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд бүртгэдэг.

ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Тайлант жилийн татвар болон хойшлогдсон татварыг эздийн өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогоор шууд хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ

Компани энгийн хувьцааны хувьд нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашиг, алдагдлыг тайлант хугацааны туршид эргэлтэнд байсан энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд хуваах замаар нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог.

ХОЛБООТОЙ ТАЛУУД

Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд компанитай холбоотой гэж үзнэ:

- Компанийг хянадаг эсвэл хамтран хянадаг;
- Компанид мэдэгдэхүйц нөлөөлөлтэй;

- Компанийн эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

Хувь хүний гэр бүлийн ойр дотны гишүүд гэдэг нь компанитай ажил хэргийн харилцаанд орох явцад хувь хүнд нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд автаж болзошгүй гэр бүлийн гишүүд юм.

ТАЙЛБАР ТОЛЬ

ТАЙЛАНТ ҮЕ

Аж ахуйн нэгж, байгууллагын ашиг, алдагдлыг тооцож буй хугацааг хэлнэ. Ерөнхийдөө улирал, жилийг хамруулж авч үзнэ.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Иж бүрэн санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдэнэ.

ХӨРӨНГӨ

Хөрөнгө гэдэг нь өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болж, байгууллагын мэдэлд орсон бөгөөд ирээдүйд үр өгөөжөө өгөх нөөц, баялаг, хөрөнгө юм.

ББХ-БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгөтэй адил биетээр, бодитоор оршдоггүй хэдий ч эзэмшигчдэдээ давуу тал болон давуу эрхийг олгодог патент, лиценз, зохиогчийн эрх, барааны тэмдэг, нэр төр, гүүдвил гэх мэт удаан хугацаанд үнэ цэнэтэй байх актив (хөрөнгө)-ыг хэлнэ.

ҮХ-ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Байшин, барилга, машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил гэх мэт худалдан борлуулах зориулалтгүй, үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаанд урт хугацаанд ашиглагдах буюу 1 жилээс бага хугацаанд борлогдож мөнгөн хөрөнгө болохгүй хөрөнгийг хэлнэ.

ЭБХ-ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийг хэлнэ.

ЭХ-ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулахад

ашиглагдах нэг жил буюу түүнээс бага хугацаанд бэлэн мөнгө болж хувирах хөрөнгийг хэлнэ.

УТЗ-УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ

Ажил үйлчилгээ авахаас өмнө буюу үр дүн нь гарахаас өмнө төлсөн төлбөр

ДАНСНЫ АВЛАГА

Үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах мөнгөн дүн.

БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ
3 сараас нэг жилийн хугацаатай хадгаламж, богино хугацаат хөрөнгө оруулалт хамаарна.

МӨНГӨТЭЙ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Үнэ цэнийг нь өөрчлөхөд өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөнд шууд хөрвөх нэгээс гурван сарын хугацаатай хөрөнгө оруулалт юм.

МӨНГӨН СУУРЬТ АРГА

Бэлнээр мөнгө хүлээж авсан үед нь орлогод, бэлнээр мөнгө төлсөн үед нь зардалд бүртгэх нягтлан бодох бүртгэлийн арга.

АККРУЭЛ СУУРЬТ АРГА

Мөнгө хүлээн авсан, эсхүл төлснөөс үл хамааран ажил үйлчилгээний гүйцэтгэлтэй уялдуулан орлогыг олсон, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.

ХУВЬЦААТ КАПИТАЛ

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө юм.

ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ

Аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үнэ дахин үнэлгээний үр дүнд өссөн дүнг хэлнэ.

ӨР ТӨЛБӨР

Бусдад төлөх ёстой мөнгө (хувь хүн, компани, эсхүл Засгийн газрын өр байж болно).

УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийг хэлнэ.

БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

12 сарын дотор төлбөр нь төлөгдөх өр төлбөрийг хэлнэ.

НДШ-НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг санхүүжүүлэх зорилгоор ажилчид болон ажил олгогчдод ногдуулах татвар.

ОТ-ОРЛОГЫН ТАЙЛАН

Компанийн олсон орлого, гаргасан зардлыг тодорхой хугацаагаар (улирал, жил) тасалбар болгон харуулсан тайлан **БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО**

Тайлангийн хугацаанд худалдсан бараа, бүтээгдэхүүн үйлчилгээний үйл ажиллагаанаас олсон орлогыг хэлнэ.

БОРЛУУЛАЛТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

Тайлант үед борлуулсан барааны өртгийг хэлнэ.

НИЙТ АШИГ

Байгууллагын тодорхой хугацаан дахь үйл ажиллагааны үр дүнгийн мөнгөн илэрхийлэл буюу бизнес эрхэлж, эрсдэл хүлээсний төлөө авч буй үр өгөөж, компанийн нийт орлогоос бүх мөнгөн болон хийсвэр зардлыг хасч тооцно.

ҮАЗ-ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Бизнес эрхлэхэд гарч буй зардал.

ХТӨА

Хүү татварын өмнөх ашиг

ЦЭВЭР АШИГ

Компанийн орлогоос бүх төрлийн зардал болон татварыг хасаад үлдэж буй ашгийн хэмжээ.

ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ

Орлогын албан татварын зардал нь орлогын албан татварын өмнөх ашиг нь хувиар илэрхийлсэн

ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

Засгийн газраас аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогод ногдуулж буй татвар

МГТ-МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Байгууллагын тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн өөрчлөлтийг харуулсан тайлан

ҮҮАМГ

Үндсэн Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ байгууллагын орлого олох үндсэн үйл ажиллагаанаас орж ирэх мөнгөн хөрөнгийг хэлнэ

ГХО

Гадаадын хөрөнгө оруулалт

APU COMPANY  ЖИЛ
Төгс. Төгөлдөр. Тунгалаг.



Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/			
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>			
<i>Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/</i>		2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр	
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>		Нэр: АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ УБГД: 000165753, РД: 2702673 ҮЦКод: АПУ /90/ Утас: 11-344336	
<i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>		Монголын хөрөнгийн бирж	
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>		Шингэн хүнсний үйлдвэрлэл	
<i>Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо</i>		“Солид Юнити Аудит” ХХК, 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр	
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>		1,064,181,553	
<i>Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>		Санхүү, тайлагналын албаны дарга Ж.Оюумаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан	
<i>1. Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>			
<i>Санхүүгийн байдлын үзүүлэлт</i>	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	Хөрөнгө		
	Эргэлтийн хөрөнгө	351,152,026,000.00	448,952,351,816.87
	Эргэлтийн бус хөрөнгө	490,982,398,000.00	569,528,947,000.00
	Нийт хөрөнгө	842,134,424,000.00	1,018,481,298,816.87
	Өр төлбөр ба эздийн өмч		
	Богино хугацаат өр төлбөр	129,643,932,000.00	157,674,499,116.78
	Урт хугацаат өр төлбөр	78,913,248,000.00	180,231,143,387.43
	Эздийн өмч	633,577,244,000.00	680,575,656,312.66
	Нийт өр төлбөр ба эздийн өмч	842,134,424,000.00	1,018,481,298,816.87
	<i>Орлогын тайлан</i>	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл
Борлуулалтын орлого (цэвэр)		850,239,813,487	1,105,352,126,000
Борлуулалтын өртөг		(478,212,778,487)	(625,950,191,183)
Нийт ашиг (алдагдал)		372,027,035,000	479,401,934,817
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		154,112,211,000	157,663,407,644
Орлогын татварын зардал		(28,214,649,000)	(40,605,307,000)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		125,897,562,000	117,058,100,644
Бусад дэлгэрэнгүй орлого		66,117,907,000	1,853,596,000
Нийт орлогын дүн		192,015,469,000	118,911,696,644
Толгой компанийн хувьцаа эзэмшигчэд ноогдох		210,810,663,000	148,648,154,644
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох		(18,795,194,000)	(29,736,458,000)

		Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>		Өмч	106,418,200.00	106,418,200.00		
		Халаасны хувьцаа	(120,700.00)	-		
		Нэмж төлөгдсөн капитал	225,299,065,200.00	226,646,951,295.79		
		Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	156,566,882,000.00	157,839,025,853.57		
		Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	703,518,000.00	(56,565,000.00)		
		Хуримтлагдсан ашиг	220,738,414,200.00	274,269,754,963.30		
		Нийт эздийн өмчийн дүн	603,414,176,900.00	658,805,585,312.66		
		Хяналтын бус хувь оролцоо	30,163,069,000.00	21,770,071,000.00		
	Нийт дүн	633,577,245,900.00	680,575,656,312.66			
<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>		Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
		Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	112,645,636,000.00	184,382,607,000.00		
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(92,776,665,000.00)	(117,469,073,000.00)		
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(60,638,967,000.00)	18,853,189,000.00		
		Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(40,769,996,000.00)	85,766,723,000.00		
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	77,277,746,000.00	38,365,142,000.00		
		Мөнгөн хөрөнгийн үнэ цэнийн бууралт болон валютын ханшийн өөрчлөлт	1,857,392,000.00	(1,979,681,000.00)		
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	38,365,142,000.00	122,152,184,000.00		
		1.1. Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт				
		- Хавсралтаар оруулав.				
1.2. Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/						
- Байхгүй.						
2. Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл						
2.1. Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/		Харьцаанууд	2022	2023		
		Нийт ашгийн хувь	44%	43%		
		Үйл ажиллагааны ашгийн хувь	18%	14%		
		Цэвэр ашгийн хувь	15%	11%		
		Өөрийн хөрөнгийн өгөөж	21%	18%		
		Нэгж хувьцаанд ногдох ашиг	136,120.56	137,941.22		
2.2. Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт		Харьцаанууд	2022	2023		
		Эргэлтийн харьцаа	2.71	2.85		
		Гүргэн хөрвөх чадварын харьцаа	0.77	1.27		
		Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	0.33	0.50		
2.3. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл		- Инфляци болон гадаад валютын ханшийн өсөлт, нийлүүлэлтийн гинжин сүлжээний үнийн өсөлтөөс хамаарч түүхий эд материалын үнэ өсөж, улмаар бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ өсөхөд шууд нөлөөлж байна. Үүний эсрэг ажлын капиталын удирдлага болон санхүүгийн хэрэгслүүдийг ашиглах замаар хариу арга хэмжээ авч ажиллаж байна.				

2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	- Балансын гадуурх ажил гүйлгээ байхгүй болно.																																																																					
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	<table border="1"> <tr> <td></td> <td>Зээл</td> <td>Нийт дүн</td> </tr> <tr> <td>Авсан зээл</td> <td></td> <td>230,570,440,000</td> </tr> <tr> <td>Төлсөн зээл</td> <td></td> <td>105,900,000,000</td> </tr> </table>			Зээл	Нийт дүн	Авсан зээл		230,570,440,000	Төлсөн зээл		105,900,000,000																																																											
	Зээл	Нийт дүн																																																																					
Авсан зээл		230,570,440,000																																																																					
Төлсөн зээл		105,900,000,000																																																																					
3.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p> <p>Их хэмжээний хэлцэл:</p> <ul style="list-style-type: none"> - Их хэмжээний хэлцэл тухайн тайлант жилд гараагүй. <p>Сонирхлын зөрчилтэй хэлцэл:</p> <ul style="list-style-type: none"> - Адуитын тайлангийн дэлгэрэнгүй тайлангийн тодруулга хэсэгт холбоотой талуудын ажил гүйлгээнээс гадна сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн гүйлгээний жагсаалтыг тодруулсан болно. Үүнээс өөр гүйлгээ байхгүй болно. 																																																																						
4.	<p>Цалин урамшууллын мэдээлэл</p> <p>Цалин урамшууллын бодлогыг ТУЗ-ийн 2023 оны 01 сарын 24-ний өдрийн хурлаар шинэчлэн баталсан бөгөөд тус бодлого нь Компанийн хэмжээнд баримтлах цалин хөлс, урамшууллын зарчмыг тодорхойлж, ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд, нийт ажилтны цалин хөлс, урамшууллын тогтолцооны үндсийг тогтооход чиглэгдэнэ. Компани нь цалин урамшууллын тогтолцоонд дараах суурь зарчмыг баримтална. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Зах зээлд өрсөлдөхүйц цалин урамшууллын тогтолцоогоор дамжуулан мэргэшсэн, өндөр ур чадвартай ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах; ✓ Ижил үнэлэмж бүхий хөдөлмөрт адил цалин, урамшуулал олгох, гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан цалин урамшууллын хуваарилалт аливаа ялгаварлал, гадуурхал, тэгш бус байдлаас ангид байх; ✓ Цалин урамшууллыг ажилтны мэдлэг, ур чадвар болон ажлын байрны үнэлгээ, үнэ цэнд суурилж тогтоох. <p>ТУЗ-ийн цалин, урамшуулал</p> <p>Цалин урамшууллын бодлогод ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувыцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталж, гүйцэтгэлийг Компанийн жилийн тайланд тодорхой тусгахаар заасан. ТУЗ-ийн дарга болон гишүүдэд сар бүр тогтмол цалин олгодог ба нэмэлт урамшуулал олгодоггүй. 2023 онд ТУЗ-ийн цалин, урамшууллын хэмжээнд өөрчлөлт ороогүй.</p> <p>ТУЗ-ийн гишүүдэд 2023 онд олгосон цалин, урамшуулал</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>ТУЗ-ийн гишүүн</th> <th>Сарын үндсэн цалин (төг)</th> <th>Олговол зохих нийт цалин (төг)</th> <th>Суутгалын дүн (НДШ, ХХОАТ)</th> <th>Гарт олгосон нийт цалин</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>П.Батсайхан</td> <td>10,000,000</td> <td>120,000,000</td> <td>18,712,200</td> <td>101,287,800</td> </tr> <tr> <td>2</td> <td>Б.Багбаяр</td> <td>6,500,000</td> <td>78,000,000</td> <td>14,512,200</td> <td>63,487,800</td> </tr> <tr> <td>3</td> <td>Сергей Громов</td> <td>6,500,000</td> <td>78,000,000</td> <td>14,512,200</td> <td>63,487,800</td> </tr> <tr> <td>4</td> <td>Кеннет Чу</td> <td>6,500,000</td> <td>78,000,000</td> <td>23,190,000</td> <td>54,810,000</td> </tr> <tr> <td>5</td> <td>Сэн И-Ин</td> <td>6,500,000</td> <td>78,000,000</td> <td>23,190,000</td> <td>54,810,000</td> </tr> <tr> <td>6</td> <td>Д.Миеэгомбо</td> <td>6,500,000</td> <td>78,000,000</td> <td>14,512,200</td> <td>63,487,800</td> </tr> <tr> <td>7</td> <td>Ё.Гэрэлчулуун</td> <td>6,500,000</td> <td>78,000,000</td> <td>13,324,200</td> <td>64,675,800</td> </tr> <tr> <td>8</td> <td>Ж.Үнэнбат</td> <td>6,500,000</td> <td>78,000,000</td> <td>14,512,200</td> <td>63,487,800</td> </tr> <tr> <td>9</td> <td>О.Одбаяр</td> <td>6,500,000</td> <td>78,000,000</td> <td>14,512,200</td> <td>63,487,800</td> </tr> <tr> <td></td> <td>НИЙТ</td> <td>62,000,000</td> <td>744,000,000</td> <td>150,977,400</td> <td>593,022,600</td> </tr> </tbody> </table>					№	ТУЗ-ийн гишүүн	Сарын үндсэн цалин (төг)	Олговол зохих нийт цалин (төг)	Суутгалын дүн (НДШ, ХХОАТ)	Гарт олгосон нийт цалин	1	П.Батсайхан	10,000,000	120,000,000	18,712,200	101,287,800	2	Б.Багбаяр	6,500,000	78,000,000	14,512,200	63,487,800	3	Сергей Громов	6,500,000	78,000,000	14,512,200	63,487,800	4	Кеннет Чу	6,500,000	78,000,000	23,190,000	54,810,000	5	Сэн И-Ин	6,500,000	78,000,000	23,190,000	54,810,000	6	Д.Миеэгомбо	6,500,000	78,000,000	14,512,200	63,487,800	7	Ё.Гэрэлчулуун	6,500,000	78,000,000	13,324,200	64,675,800	8	Ж.Үнэнбат	6,500,000	78,000,000	14,512,200	63,487,800	9	О.Одбаяр	6,500,000	78,000,000	14,512,200	63,487,800		НИЙТ	62,000,000	744,000,000	150,977,400	593,022,600
№	ТУЗ-ийн гишүүн	Сарын үндсэн цалин (төг)	Олговол зохих нийт цалин (төг)	Суутгалын дүн (НДШ, ХХОАТ)	Гарт олгосон нийт цалин																																																																		
1	П.Батсайхан	10,000,000	120,000,000	18,712,200	101,287,800																																																																		
2	Б.Багбаяр	6,500,000	78,000,000	14,512,200	63,487,800																																																																		
3	Сергей Громов	6,500,000	78,000,000	14,512,200	63,487,800																																																																		
4	Кеннет Чу	6,500,000	78,000,000	23,190,000	54,810,000																																																																		
5	Сэн И-Ин	6,500,000	78,000,000	23,190,000	54,810,000																																																																		
6	Д.Миеэгомбо	6,500,000	78,000,000	14,512,200	63,487,800																																																																		
7	Ё.Гэрэлчулуун	6,500,000	78,000,000	13,324,200	64,675,800																																																																		
8	Ж.Үнэнбат	6,500,000	78,000,000	14,512,200	63,487,800																																																																		
9	О.Одбаяр	6,500,000	78,000,000	14,512,200	63,487,800																																																																		
	НИЙТ	62,000,000	744,000,000	150,977,400	593,022,600																																																																		

Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал

Цалин урамшууллын бодлогод Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал үндсэн цалин, урамшууллаас бүрдэж, ТУЗ-тэй байгуулсан гэрээгээр тодорхойлогдохоор заасан.

Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал (хувь хүн) хэрэгжүүлдэг. Гүйцэтгэх захирлыг сонгох, чөлөөлөх, бүрэн эрхийг тогтоох, түүнтэй байгуулах гэрээний нөхцөл, цалин, шагнал урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох нь ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарна.

АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал нь Компанийн охин компаниуд болох АПУ Трейдинг ХХК, М Би Си Азиа Пасифик ХХК, СББ Трейд ХХК, Спирт бал бурам ХХК, ӨМӨЗО-ны Эйпиюү Трейд ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар давхар томилогдон ажилладаг.

Гүйцэтгэх захиралд ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан үндсэн цалингаас гадна “борлуулалтын орлого”, “хүү, татварын өмнөх ашиг”, “зардлын хэмнэлт”, “хүн ба байгууллагын хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл болон байгууллагын соёлыг сайжруулах ажлуудын үр дүн” гэсэн 4 үндсэн шалгуур үзүүлэлтийг ижил хувийн жинтэйгээр тооцож, урамшуулал олгодог.

Компанийн ажилтны цалин, урамшуулал

Цалин урамшууллын бодлогод Компанийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд болон нийт ажилтны цалин, урамшууллыг Гүйцэтгэх захирал тогтоодог.

5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

АПУ Групп компанийн бүтэц



Бүтцэд өөрчлөлт гараагүй.

Хувьцаа эзэмшигчдийн хурал

АПУ ХК-ийн эрх барих дээд удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14:00-15:40 цагийн хооронд 92.43%-ийн ирцтэй хуралдаж, дараах шийдвэрүүдийг гаргав:

1. АПУ ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан “АПУ групп компани 2022 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан” гэсэн дүгнэлтийг хуралд оролцож, хүчинтэй санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.
2. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг ТУЗ-ийн дарга 10 сая, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая байхаар хуралд оролцож, хүчинтэй санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 99.99%-ийн саналаар батлав.

Төлөөлөн удирдах зөвлөл

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт ТУЗ компанийг удирддаг. ТУЗ нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн дотоод журамд заасан АПУ ХК-ийн ТУЗ-ийн болон түүний охин, хараат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлдэг.

ТУЗ-ийн бүрэлдэхүүн

Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 29-ний өдрийн хурлаар 3 жилийн хугацаатай сонгосон ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.



ПҮРЭВИЙН БАТСАЙХАН
ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга

Инженер мэргэжилтэй
Шуудны дэвсгэлийн хэлтэсийн дарга
2022 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга
Хувьцаа эзэмшил: 0.03%



БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР

ТУЗ-ийн ердийн гишүүн
Эдийн засагч мэргэжилтэй
Шуудны дэвсгэлийн хэлтэсийн дарга
2022 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.05%



СЕРГЕЙ ГРОМОВ

ТУЗ-ийн ердийн гишүүн
Инженер мэргэжилтэй
Монгол Дэлгэц ХК-ийн ТУЗ-ийн дарга
2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.09%



КЕННЕТ ЧУ

ТУЗ-ийн ердийн гишүүн
Мэргэжлийн зөвлөлийн гишүүн
Хөгжлийн Дэлгэц ХК-ийн ТУЗ-ийн дарга
2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



СЭН И-ИН

ТУЗ-ийн ердийн гишүүн
Бурхан мэргэжилтэй
Хөгжлийн Дэлгэц ХК-ийн ТУЗ-ийн дарга
Монгол Дэлгэц ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
2022 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



ДОРЖИЙН МИЕЭГОМБО

ТУЗ-ийн ердийн гишүүн
Бурхан мэргэжилтэй
ТЭС ХК-д орлогч
2022 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



Одончимэдийн ОДБАЯР

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Бэлтгэл, эрх зүйч мэргэжилтэй
Ард дэвсгэл ХК, Ард нэгдэл ХКХ, Монгол Уурдал ХХ-ийн ТУЗ-ийн гишүүн
2022 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



ЕНДОН-ОЙДОВЫН ГЭРЭЛЧУЛУУН

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Эдийн засагч мэргэжилтэй
2022 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Эдийн засагч мэргэжилтэй
2022 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцаа эзэмшил: 0.00%



ЧАДРААБАЛЫН АРИУНСАН










ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд дарга

ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан

ТУЗ нь танхимаар, танхим-цахим хосолсон, эчнээ санал хураалтын хэлбэрээр нийт 14 удаа, дунджаар 98%-ийн ирцтэй хуралдаж, бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 55 тогтоол гаргав.

Баталсан тогтоолын тоо												
Д/д	Огноо	Ирц	Нийт	АПУ ХК	АПУ Дэйри ХХК	АПУ Трейдинг ХХК	М Би Си Аэко Пасифик ХХК	СББ Трейд ХХК	Спирт бал бурам ХХК	ОХУ-ын Гранд ХХК	ОХУ-ын Гранд Ист ХХК	БНХАУ ӨМӨЗО-ны Эйлиму трейд ХХК
				ТУЗ-ийн хурал	Хувьцаа эзэмшигчдийн хурал							
1	2023.01.24	100%	1	1								
2	2023.02.13	100%	12	3	2	1	1	1	1	1	1	1
3	2023.03.17	100%	1	1								
4	2023.03.28	89%	5	1	3				1			
5	2023.04.28	100%	1	1								
6	2023.05.24	100%	1	1								
7	2023.07.04	100%	4	1	2		1					
8	2023.08.09	100%	5	4	1							
9	2023.09.05	100%	1	1								
10	2023.09.21	100%	1		1							
11	2023.10.06	100%	1		1							
12	2023.11.13	100%	9	3	2	1	1	1	1			
13	2023.12.05	89%	12	3	2	1	1	1	1	1	1	1
14	2023.12.22	100%	1	1								
	Нийт	98%	55	21	14	3	4	3	4	2	2	2

Жилийн турш ТУЗ-ийн гишүүн бүрийн хуралд оролцсон ирц

П.Батсайхан		100%
Б.Батбаяр		100%
Сергей Громов		100%
Кеннет Чу		100%
Сэн И-Ин		100%
Д.Миеэгомбо		93%
Ё.Гэрэлчулуун		100%
О.Одбаяр		93%
Ж.Үнэнбат		100%

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Компанийн тухай хуулийн 81.2-т заасны дагуу ТУЗ-ийн дэргэд Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо ажилладаг бөгөөд хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн юм.

ТУЗ-ийн дэргэдэх хороод Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, хороодын дүрэмд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллахдаа Аудитын хороо 3 удаа, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо тус бүр 1 удаа хуралдаж, хариуцсан чиг үүргийн хүрээнд санал, дүгнэлт, шийдвэр гаргаж ажиллав.

ТУЗ-ийн хороо	Хуралдсан тоо	Бүрэлдэхүүн	ТУЗ-ийн гишүүний хэлбэр	Нэрс
Аудитын хороо	3	Хорооны дарга	Хараат бус гишүүн	Ж.Үнэнбат
		Гишүүн	Ердийн гишүүн	Сэн И-Ин
		Гишүүн	Хараат бус гишүүн	О.Одбаяр
Нэр дэвшүүлэх хороо	1	Хорооны дарга	Хараат бус гишүүн	О.Одбаяр
		Гишүүн	Ердийн гишүүн	П.Батсайхан
		Гишүүн	Хараат бус гишүүн	Ё.Гэрэлчулуун
Цалин урамшууллын хороо	1	Хорооны дарга	Хараат бус гишүүн	Ё.Гэрэлчулуун
		Гишүүн	Ердийн гишүүн	Ж.Үнэнбат
		Гишүүн	Хараат бус гишүүн	Кеннет Чу

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээ

АПУ ХК-аас Кодексийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээг 2023 онд хоёр удаа хийсэн ба СЗХ-ны Компанийн засаглал, комплайнсын хэлтсээс тухай бүр хянан баталгаажуулсан үр дүнг дор үзүүлэв. АПУ ХК кодексийн хэрэгжилтийн үнэлгээгээр Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниудаас 2023 оны эхний хагас жилд 90%-ын үнэлгээгээр 7-р байранд, 2023 оны эцэст 93%-ийн үнэлгээгээр 4-р байранд тус тус эрэмбэлэгдлээ.

АПУ ХК-ИЙН "КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС"-ИЙН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	2023 оны I хагас жил		2023 оны эцэс	
			Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	11	92%	10	83%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%	10	100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	4	67%	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	7	88%	7	88%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%	6	100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%	8	100%
8	Компанийн соёл	6	5	83%	5	83%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	8	80%	9	90%
Нэгдсэн дүн		72	65	90%	67	93%
			Засаглал хэвийн буюу эрсдэлгүй		Засаглал хэвийн буюу эрсдэлгүй	

б. Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл

АПУ ХК нь байгаль орчин, нийгэм, эдийн засагт ээлтэй засаглалыг бэхжүүлэхэд чиглэн ажиллаж байна. Үүний тулд бид эрсдэлийн удирдлагын шинэ чиг хандлага болох тогтвортой хөгжилд чиглэсэн эрсдэлийн удирдлагын соёлыг түгээн дэлгэрүүлэхэд ихээхэн анхаарч, аливаа болзошгүй эрсдэл, тодорхойгүй нөхцөл байдлыг урт хугацаандаа оновчтой удирдах, шинэ боломжуудыг эрэлхийлэн ажилласаар ирлээ.


Ирэх жилүүдэд дэлхий дахинд төдийгүй манай салбарын үйл ажиллагаанд шууд болон дам байдлаар нөлөөлөх дараах таван чиглэлийн эрсдэлийг бид онцолж байна. Үүнд байгаль цаг уурын өөрчлөлт, хүлэмжийн хийн асуудлууд, геополитикийн зөрчилдөөн, үүнээс үүдсэн эдийн засгийн тодорхойгүй байдал, шинэчилсэн хуулийн шаардлагууд, болон мэдээллийн оновчтой бус урсгалын нөлөөллүүд багтана.

Нэг нь нөгөөгөөсөө харилцан уялдаа холбоотойгоор орших эдгээр эрсдэлүүд нь бидний бизнесийн үйл ажиллагаанд цогцоороо томоохон сорилтуудыг дагуулж байна. Ялангуяа байгаль цаг уурын өөрчлөлт нь зарим бүс нутагт их хэмжээний хур тунадас, үерийн аюул дагуулж байгаа бол өөр нэг хэсэгт ган зуд болох эрсдэлийг учруулснаар хөрсний гулгалт, элэгдэл үүсэх, гал түймэр гарах зэргээр экосистемийн олон талт байдалд дам байдлаар, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд шууд байдлаар нөлөөлсөн үйл явдлууд өнгөрсөн онд ихээхэн тохиолдсон.

Харин урт хугацаандаа хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй эрсдэлүүд, түүн дотроо хүлэмжийн хийн ялгарал нэмэгдэх эрсдэл нь бидний хүрээлэн буй орчинд илүү ноцтой нөлөөллийг авчрах магадлалтай тул эдгээр асуудлын суурь шалтгаануудад АПУ ХК онцгой анхаарал хандуулж тогтвортой хөгжлийн зорилго, зорилтууддаа тусган, зохистой хариу арга хэмжээг төлөвлөж, шаардлагатай төсөл хөтөлбөрүүдийг санаачлан эхлүүлээд байна.

Тухайлбал: CO2 бууруулах уурын зуухны төсөл, Саарал усны хаягдлыг дахин ашиглах төсөл, Монгол бяслаг, Шигүдэри урлах үйлдвэрийн хүлэмжийн хийг бууруулах шийдлүүд, Хог хаягдлын 3R стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг дурдаж болно. Мөн бид санхүү, зардлын ухаалаг хэмнэлтийг сахин биелүүлж, урт хугацааны мөнгөн хөрөнгийн төлөвлөлттэй уялдуулан валютын форвард, своп хэлцлүүд хийн, багц бүтээгдэхүүний оновчлолыг сайжруулах замаар үйлдвэрлэлийн тасалдлаас урьдчилан сэргийлж бизнесийн ашигт ажиллагааг ханган үнэ цэнийг түгээж чадсан.

Гадаад хүчин зүйлсийн нөлөөлөл ба томоохон эрсдэлүүд



Цаг уурын өөрчлөлт, байгалийн давтагдашгүй хүчин зүйл

Эдийн засгийн тодорхойгүй байдал, ашиг орлого

Шинэчилсэн хуулийн шаардлага, нийцэл

Геополитикийн сөргөлдөөн

Мэдээллийн оновчтой бус урсгал, нэр хүндийн эрсдэл

★ Боломж


○ Дам нөлөө

○ Шууд нөлөө

Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлэийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/

Хувьцаа эзэмшигчдийн тоо¹


Хувьцаа эзэмшигчдийн тоо



¹ ҮЦТХТ ХХК-аас гаргасан 2023.12.31-ний өдрийн байдлаарх үнэт цаасны төвлөрлийн судалгааны мэдээлэл

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид²					
Д/д	Хувьцаа эзэмшигч	2022 оны эцэс		2023 оны эцэс	
		Хувьцааны тоо ширхэг	Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь
1	Шунхлай Холдинг ХХК	596,229,642	56.03	598,230,342	56.22
2	Heineken Asia Pacific Pte Ltd	266,091,981	25.00	266,091,981	25.00
3	Steppe Beverage KFT	115,769,993	10.88	112,264,896	10.55
4	Бусад	86,089,937	8.09	87,808,918	8.25
8.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</i>				
	Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.				
9.	<i>Ногдол ашгийн мэдээлэл</i>				
	Ногдол ашгийн бодлого				
	Ногдол ашгийн бодлогыг ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын 24-ний өдрийн хурлаар шинэчлэн баталсан бөгөөд тус бодлогоор Компани дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна. Үүнд:				
	<ul style="list-style-type: none"> ✓ Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх, ✓ Ногдол ашиг төлсний дараа Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс их байх, ✓ Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх. 				
	Ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг ТУЗ гаргах ба санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор, хагас жилээр ногдол ашиг хуваарилах тохиолдолд хагас жилийн санхүүгийн тайлан гарснаас хойш 30 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ.				
	ТУЗ нь ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэвэл энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн хуралд заавал тайлагнана.				
	Ногдол ашиг хуваарилалт				
	АПУ ХК-ийн ТУЗ-өөс 2023 оны нийлбэр дүнгээр компанийн хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд нийт 89 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн болно.				
	Тайлант хугацаа	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг)	ТУЗ-өөс ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн өдөр	Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр	
	2019 он	71	2020.02.14	2020.03.23	
	2020 он	95			
	Үүнээс: I хагас жил	37.5	2020.08.13	2020.09.02	
	II хагас жил	57.5	2021.02.15	2021.03.31	
	2021 он	106			
	Үүнээс: I хагас жил	46	2021.08.16	2021.09.03	
	II хагас жил	60	2022.02.17	2022.04.08	
	2022 он	89			
	Үүнээс: I хагас жил	45	2022.08.03	2022.08.22	
	II хагас жил	44	2023.02.13	2023.04.07	
	2023 он	89			
	Үүнээс: I хагас жил	45	2023.08.09	2023.08.28	
	II хагас жил	44	2024.02.16	2024.04.12	

² ҮЦТХТ ХХК-аас гаргасан 2023.12.31-ний өдрийн байдлаарх үнэт цаас эзэмшигчдийн судалгааны мэдээлэл



Ногдол ашгийн төлбөрийг нийт хувьцааны таваас доош хувийг эзэмшигчдэд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан, таваас дээш хувийг эзэмшигчдэд компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгож байна.

10.

Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл

АПУ ХК 100 жилийнхээ ойг угтан групп компанийн хэмжээнд хэрэгжих дунд хугацааны тогтвортой хөгжлийн стратегийн үндсэн тэргүүлэх чиглэлүүдээ боловсруулж, дотоод хамт олныг татан оролцуулах, мэдлэгжүүлэх ажлуудыг дотооддоо идэвхтэй хийлээ. Үүний дагуу дараагийн төлөвлөлтийн ажлууд хийгдэж байна. Стратегийн чиглэлүүдийн дагуу АПУ ХК-ийн нийгмийн хариуцлагын, том зургаараа тогтвортой хөгжлийн бүх ажлууд хэрэгжих юм.

- ✓ 7-р сард Наадмын үеэр их хэмжээгээр орсон борооны улмаас үер усны гамшиг нүүрлэхэд Онцгой комисс, Цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүн болон гамшигийн бүсэд нэгдэн ажиллаж буй аж ахуй нэгжүүдэд зориулан "Шунхлай Групп"-ийн харьяа компаниуд нэгдэж нийт 200 сая төгрөгийн шатахуун, халуун хоол, цэвэр ус, дархлаа дэмжих сүүн бүтээгдэхүүн, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл, ариутгалын спирт зэрэг бусад эд материалын дэмжлэг үзүүлэн ажилласан.
- ✓ Спирт Бал Бурам ХХК нь Мандал сумын Нэгдсэн Эмнэлгийн лабораторийг дулааны станцдаа холбож хэрэглээний төвлөрсөн халуун усны шугаманд холбож дууслаа. Уг эмнэлэг нь 1987 оноос хойш сүүлийн 35 жил хэрэглээний төвлөрсөн халуун усны шугамд холбогдоогүйн улмаас эмнэлгийн ажилтнуудад цэвэрлэгээ хийх, эрүүл мэндийн эмчилгээ үзүүлэх, хэвтэн эмчлүүлэгчид болон үйлчлүүлэгч иргэдэд хувийн ариун цэвэр сахихад хүндрэл бэрхшээл үүсгэдэг байсан энэхүү асуудал шийдэгдсэн.
- ✓ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангуулж ажиллахаар нийслэлийн нутаг дэвсгэрт нэгдсэн зохион байгуулалтаар шилмүүст мод тарих ажилд АПУ ХК компани нь 500 ширхэг шинэс мод тарихаар “НҮРИ” ХХК хамтран ажиллахаар гэрээг байгуулж ажиллалаа.
- ✓ 1400 жилийн настай Алтайн ятгын мэргэжлийн урлаач, СТА Д.Ганцүрэвээр гурван ширхэг урлуулж “Өнөр бүл” асрамжийн газрын хүүхдүүдэд хандивласан. Энэ нь тус хөгжмийн зэмсгийг сонирхон суралцах дараагийн үеийг бэлдэх эхний алхам юм. Алтайн ятгын уянгалаг аялгууг уртын дуу, орчин үеийн Регги урлагтай холбон үр хойчдоо өвлүүлэхээр Алтайн ятгын талаар нэвтрүүлэг, “ТААТАЙ ЯА” дууг мөн бүтээж олон нийтийн сонорт хүргэсэн.
- ✓ АПУ ХК-ийн бэлтгэн нийлүүлэгчдийн 75%-ийг дотоодын бэлтгэн нийлүүлэгчид эзэлдэг бөгөөд бид урт хугацаанд найдвартай бизнесийн хамтрагч байж бизнесийн өсөлт хөгжилтөд хувь нэмрээ оруулан ирээдүйн үнэ цэнийг бүтээлцэн ажиллаж байна.
- ✓ АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэр нь малчид, фермерүүдийн тогтвортой амьжиргааг дэмжих хүрээнд цаг уурын онцгой нөхцөл байдал, өвөлжилт хүндэрсэн цаг үед шингэн сүүг өндөр үнээр авч, нэн шаардлагатай байгаа 150 гаруй тонн малын тэжээлээр хангасан.
- ✓ АПУ ХК-ийн охин компани М Би Си Азия Пасифик ХХК-ийн хамт олон “Хатан Туул голоо хамтдаа цэвэрлэе” үйл ажиллагааг өөрсдийн санаачилгаар зохион байгуулж, Гачууртын эцсээс Монгол шилтгээн хүртэлх нийт 2.5 км Туул голын эргийн ай сав газрыг цэвэрлэсэн.

- ✓ Хөвсгөл нуур орчимд цуглардаг хог хаягдлыг 20 жилийн турш цэвэрлэж, ангилан ялгаж буй “Хогийн Сайнаа” хочтой ‘Хүн байгаль бүлэг’-ийн ахлагч Ж.Сайнбаяртай хамтран ажилласан. Тэрээр “Овоонд өргөдөг мөнгөө Хөвсгөл нуурыг цэвэрлэх автомашин авахад зарцуулъя” хэмээн уриалж, хандивын аян эхлүүлсэн. Ангилсан хогийг ачих автомашин авахад шаардлагатай байсан 25 сая төгрөгийн 13 сая төгрөгийг АПУ ХК хандивлаж, иргэдийн санаачилгаар хийж буй олон нөлөөллийн ажлын төлөөллийг дэмжсэн.
- ✓ НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд 10-р сарын 25-ны өдөр ажил идэвхтэй хайж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүрэлцэн ирж АПУ ХК-ийн нээлттэй ажлын байруудтай танилцан, сонирхсон иргэд ажлын байранд бүртгүүлээ.
- ✓ “Соёлоор гоёно” хөтөлбөрийн дэд хэсэг болох “Гайхамшигт жолооч - Уусан бол жолоо барьдаггүй” нөлөөллийн аяныг 2023 онд хэрэгжүүлж, 11,000 хүний амлалтыг аваад байна. Энэхүү нийгэмд чиглэсэн нөлөөллийн аян “Мөнгөн Мод 2023” наадамд “Шилдэг зар сурталчилгааны бүтээл” шагнал хүртсэн.
- ✓ Хөл бөмбөгийн спортын хөгжлийг дэмжих замаар залуучуудын эрүүл амьдралын хэв маяг, зөв дадал хэвшлийг бий болгох зорилгоор “ФС УЛААНБААТАР” хөл бөмбөгийн шигшээ багийг сүүлийн 10 орчим жилийн хугацаанд дэмжин ажиллаж байна.
- ✓ Залуучуудын эрүүл амьдралын хэв маягийг дэмжих, зөв зохистой, хариуцлагатай хэрэглээг сурталчлах зорилгоор сагсан бөмбөгийн спортын хөгжилд хувь нэмэр оруулан “Монголын Сагсан Бөмбөгийн Холбоо” /МСБХ/-той 2 дахь жилдээ хамтран Үндэсний Дээд Лиг 2023-2024 оны улирлыг зохион байгуулсан.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ц.Эрдэнэбилэг
Албан тушаал: “АПУ” ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



(Тамга/тэмдэг)

Овог, нэр: Э.Мөнхтогтох
Албан тушаал: “Солид Юнити Аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ч.Ариунсан
Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: